

**УЛС ТӨР**

Г.ЧУЛУУНБААТАР ТАМГАА  
ХҮЛЭЭН АВЛАА

II нүүрт

**ДЭЛХИЙ**

ТЕРЕЗА МЭЙ “САХИЛ ХҮРТЭХ ГЭЭД  
ШАЛ ДОРДОВ”

VII нүүрт

**Улаанбаатар: ӨНӨӨДӨР**



Дугаарын **60** мөр

Хот  
үмхийрлээ

Г.ГАНЧИМЭГ

“Аз жаргалтай” тодотголтой Улаанбаатарын иргэд үнэндээ улсынхаа нийслэлд амьдраад байна уу, нийтийн жорлонд бүтэж үхэх гээд байна уу гэлтэй л аж төрж байна. Ялангуяа, 22-ын товчоо, Буянт-Ухаа, Нисэх, Яармагийн ойролцоо байнга, салхи баруунаас байх юм бол хотын төв рүү ч хааяа хааяа цэвэрлэх байгууламжийн үмхий үнэртдэг боллоо. Тэртээ 1964 онд 500 мянган хүн амтай хотод зориулж барьсан Төв цэвэрлэх байгууламж хүнээр бол хоноогоо хүлээж байгаагаас ялгаагүй. Эцсийн бүхий л нөөц хүчээ дайчилж, бүр давуулан ажиллаж байгаа гэдэг. Уг нь энэ асуудлыг нийслэлийн нэг агентлаг хариуцаад зохицуулчих ёстой гэж дарга сайд нар үздэг ч үнэндээ хүчрэхгүй байсаар өдийг хүрчээ. Бүр УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо өнгөрсөн хавар газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцсан.

Үргэлжлэл нь III нүүрт

## ТЭДЮУ АМЛАВ

**Б.ӨНӨРТӨГТОХ**

Ердөө 14 хоногийн дараа Монголчууд бид тавдахь Ерөнхийлөгчөө “өлгийдөн” авах гэж байна. Парламентад суудал бүхий гурван намын нэр дэвшигчид албан ёсны сурталчилгаагаа өнгөрөгч даваа гарагт эхлүүлснээс хойш, хэдийнэ долоо хоног өнгөрчээ. Энэ хугацаанд аймаг, орон нутаг, сум дүүргээр орж мөрийн хөтөлбөрөө нэгбүрчлэн танилцуулахаас гадна, гишүүд дэмжигчдийнхээ урмыг үг, зарим тохиолдолд зэмлэлийг сонсч яваа. Нэр дэвшигчдийн хэлж буй үг, хийж буй үйлдэл бүрийг олон түмэн шинжиж, барианд хэн түрүүлж орох бол хэмээн өвөр зураа таамаг өрнүүлж суугаа нь дамжингүй. Монгол Улсын Ерөнхийлөгчийг бодлого тодорхойлогч гэхээс илүүтэй эв нэгдлийн бэлэг тэмдэг, бүх ард түмний сонголт хэмээн хардаг, дүгнэдэг хүмүүс бишгүй олон бий. Гэвч, хууль боловсруулах, бодлого

шийдвэр гаргах, шаардлагатай тохиолдолд УИХ, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, хариуцаагын асуудлыг хөнддөг гэдэг утгаараа Ерөнхийлөгчийн бүрэн эрх чамлахааргүй. Тэр ч утгаараа төрийн тэргүүн аль намын байхаас илүүтэй ард түмнийхээ амьдралд өөрчлөлт авчрах ямар хууль тогтоомж боловсруулах, ямар зоригтой шийдэл гаргах бол гэдэг нь юу юунаас илүү анхаарал татах сэдэв байдаг билээ. Тэгвэл “ММ” энэ удаад гурван нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрөөс улс орны амин чухал асуудал болсон цөөхөн хэдхэн сэдвийг онцолж, хооронд нь харьцуулахыг зориллоо. Тэдэн төгрөг өгнө гэсэн бэлэн мөнгөний амлалт байхгүй учраас нэр дэвшигчид Засгийн газар болон УИХ-ын бодлого шийдвэртэй уялдаж хийх, цаашлаад өөрөө бие даан хууль санаачлах боломжтой гэсэн асуудлаа мөрийн хөтөлбөртэй онцолжээ.

Үргэлжлэл нь III нүүрт

**ТОМИЛОЛТ**

### ШХАБ-ын шинэ түүх Астанагаас эхэллээ



Дэлгэрэнгүйг IV нүүрнээс

**ОНЦЛОХ МЭДЭЭ**

### Гадаадад байгаа иргэдийн санал хураалт дууслаа

Монгол Улсын Үндсэн хуульд заасанчлан Монгол Улсын иргэн бүр сонгох, сонгогдох эрхтэй. Үүнтэй холбогдуулан гадаадад ажиллаж, амьдарч буй монгол иргэдийг сонгуульд саналаа өгөх боломжоор хангадаг билээ. Тэгвэл гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монголчууд энэ сарын 10, 11-нд саналаа өглөө. Сонгуулийн төв байгууллагын мэдээлснээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нийт 7374 иргэн саналаа өгөхөөр бүртгүүлжээ. Гадаадад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдээс санал авах ажиллагааг зохион байгуулахаар Австрали, Англи, АНУ, ХБНГУ, Казахстан, ОХУ, БНСУ, БНХАУ зэрэг 32 улсад нийт 45 салбар комисс байгуулагдсан аж.

**ЧУУЛГАНЫ ТАНХИМААС**

## Монгол Улсын өрийн хэмжээ НЭГ ТЭРБУМ ам.доллараар нэмэгдлээ

**Н.БАТЗАЯА**

Энэ сард манай улсад сонгуулийн салхи сээлзэж, жаахан хэтрүүлчихэд дээд, доодгүй л өглөө ажилдаа хэдэн цагт ирэхээ мэдэхгүй болтлоо бужигнаж буй. Сонгуулийн салхи ч УИХ-ын парламентын чуулганыг орхисонгүй. Өнгөрсөн пүрэв, баасан гарагт эрхэм гишүүд маань эрчимтэйхэн ажиллаж, хэд хэдэн чухал хуулийг хам хум баталж аваад өөр өөрсдийн тойрог руу хүлгийн жолоо залав. Учир нь өөрсдийн намаас сонгуульд

сойсон нэр дэвшигчээ эрвийх дэргийхээрээ дэмжихээр явж байгаа нь энэ. Ингээд өнгөрсөн баасан гарагийн УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцэж, баталсан чухал асуудлыг тоймлон хүргэе.

Г.Чулуунбаатарыг сайдаар томилж, боловсролын салбар эзэнтэй болов

Сүүлийн хэдэн өдөр

Боловсролын салбарт томоохон үйл явдал өрнөсөн нь тус салбарын сайдыг сольсон явдал байлаа. Тодруулбал, ажиллах хугацаандаа эрхлэх асуудлын хүрээний салбарыг нэгдсэн удирдлагаар хангах, төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүргээ хангалтгүй биелүүлж, албан үүрэгтээ хариуцлагагүй хандсан гэх үндэслэлээр БСШУС-ын сайд Ж.Батсуурийг огцруулж, Ерөнхий сайд Ж.Эрдэнбат академич Г.Чулуунбаатарыг томилж тухай УИХ-д өргөн барьсан юм.

Үргэлжлэл нь II нүүрт

**ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017**

## ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГААР ТОГТНОЛЫН ТӨЛӨӨ ЭХ ОРОНЧ Х.БАТТУЛГА ЯЛНА ГЭВ

**Н.ПУНЦАГБОЛД**

Монгол орон даяар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн сурталчилгаа хуулийн дагуу үргэлжилж буй. Тэгвэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Х.Баттулга өнгөрсөн амралтын өдрүүдэд Дундговь, Төв аймаг болон нийслэлийн Налайх, Багануур, Баянгол дүүргийн иргэд, сонгогчидтойгоо уулзлаа. Тухайлбал, нэр дэвшигч Х.Баттулга өнгөрсөн ням гарагт Баянгол дүүрэгт Улаанбаатар хот дахь сонгуулийн сурталчилгааны нээлтээ амжилттай хийлээ.

Үргэлжлэл нь V нүүрт



Гэрэл зурагч Г.АРИУУЖИН

# МОНГОЛЫН МЭДЭЭ

19 ДЭХ ЖИЛДЭЭ

**Манай сонины  
III улирлын  
захиалга  
үргэлжилж  
байна**

Улиралд **44** дугаар

**Захиалгын үнэ  
19800**

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай post: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

ХААН банк				Хугалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2368.00	2389.00	ФУНТ	2973.00	3073.00	АМ.ДОЛЛАР	2368.00	2389.00
ЕВРО	2627.00	2701.00	РУБЛЬ	40.80	42.60	ЕВРО	2602.00	2713.00
ИЕН	21.35	21.80	ЮАНЬ	348.00	352.00	ИЕН	21.05	22.04
						ФУНТ	2964.00	3089.00
						РУБЛЬ	39.50	44.87
						ЮАНЬ	348.00	352.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

### Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил АНУ-д айлчилна

Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил энэ сарын 12-14-нд АНУ-д албан ёсны айлчлал хийхээр болжээ. Айлчлалаар АНУ-тай өндөр төвшний яриа хэлэлцээг тогтмолжуулах, улс төр, худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бодит алхмууд хийх болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хэлхээ холбоог гүнзгийрүүлэх асуудлаар санал солилцох гэнэ. Тэрбээр айлчлалын хүрээнд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон, Цагаан Ордны Үндэсний аюулгүй байдлын зөвлөх, дэслэгч генерал Х.МакМастер, АНУ-ын Ерөнхийлөгчийн Шадар туслах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Азийн асуудал харуусан Тэргүүн захирал М.Поттинжир, АНУ-ын Конгресс дахь Ардчиллын түншлэлийн Хөтөлбөрийн дарга, Конгрессын гишүүн П.Роскам болон Конгресс дахь Монголын бүлгийн дарга нар, Мянганы сорилтын корпораци, Энхтайвны корпусын удирдлагуудтай тус тус уулзах юм байна. Мөн Монгол дахь Америкийн Худалдааны Танхимаас зохион байгуулах Монгол-Америкийн бизнесийн дөрөвдүгээр уулзалт, Хөрөнгө оруулагчдын дугуйширээний уулзалтад оролцож, улс орныхоо эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг тогтвортой байлгах, тэдний итгэлийг сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлж буй Засгийн газрын бодлого, арга хэмжээний талаар мэдээлэх ажээ. Уг үйл ажиллагаанд Монголд хөрөнгө оруулалттай, хөрөнгө оруулах сонирхолтой, АНУ-тай бизнесийн хамтын ажиллагаа явуулж буй Монгол, Америкийн 50 гаруй аж ахуйн нэгж компани оролцоно.

# МОНГОЛ УЛСЫН ӨРИЙН ХЭМЖЭЭ НЭГ ТЭРБУМ АМ.ДОЛЛАРААР НЭМЭГДЛЭЭ



Гэрэл зургийн Т.АРГУУЖИН

### Үргэлжлэл. Түрүүч нь 1 нүүрт

Уг асуудлыг УИХ-аар хэлэлцэж, 49 гишүүн дэмжсэнээр академич Г.Чулуунбаатар БСПШУС-ын сайдаар томилогдоо. Энэ үеэр гишүүд Г.Чулуунбаатарт хандаж, үг хэлсэн юм. Тухайлбал, УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагва “Энэ их том салбар, дөрвөн салбар багтсан. Монгол Улсыг дэлхийд гаргах ганц зүйл нь түүх, соёл. Тиймээс үүнд анхаарч боловсролын салбарын сайдаар очиж байна. Эрдэмтэн хүн мундаг л даа. Гэхдээ салбар хариуцсан сайд гэдэг албан тушаал хүнээс сайн улстөрч, сайн менежер байхыг шаарддаг. Улаанбаатар хотын захын дүүргүүдийн ачаалал хэд дахин илүү байдаг. Түүнийг дагаад ажилчдынх нь ачаалал ч их. Хэдийгээр зуны амралт эхэлсэн ч ажлаа аваад сургууль, цэцэрлэгт өөрийн биеэр очоосой гэж хүсч байна. Боловсролын салбарт дутагдаж байгаа нэг зүйл нь мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх явдал. Монгол Улсын үйлдвэр аж ахуйг дэмжих тийм л хүмүүс хэрэгтэй байна. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд онцгойлон анхаарч ажиллаарай” гэв. Харин УИХ-ын гишүүн Л.Болд “Нийслэл ачааллаа дийлэхээ больсон. Оюутнуудын амралт эхлэхээр л амьсгалахад чөлөөтэй болдог. Бид Багануур дүүрэгт оюутны комплекс байгуулах гээд мөн ч олон жил боллоо. Их, дээд сургуулийн хотоос гаргана гэхээр сургуулийн удирдлагууд хоорондоо лобби зохионо. Сайхан оюутны комплекс барьчихвал сургуулиуд өөрсдөө гарах гэж хичээдэг болно шүү дээ” гэдгийг онцлов.

дын 1.0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийг 2015 оны арваннэгдүгээр сарын 10-нд байгуулж, мөн оньхоо арваннэгдүгээр сарын 26-нд УИХ-аар соёрхон баталсан билээ. Тэгвэл УИХ-ын нэгдсэн чуулганы баасан гарагийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Экспорт-Импорт банк хоорондын хөнгөлөлттэй зээлийн Ерөнхий хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээ. Уг хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбаогт танилцуулав. Энэхүү зээлийг авснаар Монгол Улс дэд бүтэц, эрчим хүч, хөдөө аж ахуйн салбарт голлон зарцуулна. Харин зээлийн хэлэлцээрийн нөхцөл нь жилийн хоёр хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай юм. Манай улс зээл хэрэгжих эхэлсэнээ хойш долоон жилийн дараа зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх аж. Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл тус бүрийн 85 хувийг БНХАУ-ын Засгийн газар, 15 хувийг Монгол Улсын Засгийн газар санхүүжүүлэх нөхцлийг өөрчлөх талаар хэлэлцээ хийж, БНХАУ-ын Засгийн газар санхүүжүүлэх хэмжээг 95 хувь болгон нэмэгдүүлэхээр тохиролцжээ. Энэ үеэр гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Энэ талаархи мэдээллийг дэлгэрэнгүй хүргэе.

ын Засгийн газраас Лаус, Комбаж, Вьетнам зэрэг улсад анх удаа хөнгөлөлттэй зээл өгч эхэлсэн юм билээ. Тэр улсууд зээл аваад хэд дахин цахилгаан станцаа барилдчихсан. Гэтэл бид 2004 оноос хойш “Эгийн голын цахилгаан станц”-ын талаар яриад л суугаад байдаг. Ингэж л бид хөгжлийг гацаагч нар болчихоод байгаа юм. Одоо дахиад хөнгөлөлттэй зээл ороод ирэхээр болохгүй гэж яриад байна. Болох болохгүйг, хийж чадах, чадахгүйг бид өөрсдөө нөхцөлөө тавьж гэрээ хэлэлцээр хийж шийднэ. Түүнээс өгөх гэж байгаа хүмүүсээ муулаад эхлэхээр юу болох вэ. Нэг зээл авах гэж 13 жил ярилцсан байна. Зээл авах гэхээр хөршгүйгөө улс төр ярих юм. Гэтэл БНХАУ-тай хөрш бусад орнууд зээл аваад хэд хэдэн цахилгаан станц битгий хэл бүтээн байгуулалт хийчихсэн байна.

### Н.Энхболд: Хөдөө аж ахуйн холбогдолтой зээлийг хариуцлага хүлээх чадвартай хоршоодоор дамжуулж хэрэгжүүлэх ёстой

“Зээлийг дэмжиж байна. Хөдөө аж ахуйн холбогдолтой зээлүүдэд барих бодлогын талаархи саналыг П.Сэргэлэн сайдад хэлэе. 2004-2005 онд Монголын төрөөс хөдөө аж ахуйг дэмжих талаар гаргасан бүх шийдвэрүүд бэлчээрийн даац, малын ашиг шимийн нэмэгдэлтэй холбогдуулаад үйлдвэрлэлүүдийг зохион байгуулалттайгаар малчдын бүлэг, хоршоодоор дамжуулан хийе гэдэгт тулгуурлан гарч байсан. Бүгдэнд нь хоршоо, малчдын бүлгийн тухай бий. Харамсалтай нь Засгийн газар солигдохоор урьдын бодлого шийдвэр нь өөрчлөгдөж, уламжлалт чанараа алддаг. Хөдөө аж ахуйн холбогдолтой авч буй зээлийг аль болох

...Гэтэл бид 2004 оноос хойш “Эгийн голын цахилгаан станц”-ын талаар яриад л суугаад байдаг. Ингэж л бид хөгжлийг гацаагч нар болчихоод байгаа юм. Одоо дахиад хөнгөлөлттэй зээл ороод ирэхээр болохгүй гэж яриад байна. Болох болохгүйг, хийж чадах, чадахгүйг бид өөрсдөө нөхцөлөө тавьж гэрээ хэлэлцээр хийдэг...

хариуцлага хүлээх чадвартай хоршоо, малчдын бүлэг, хуулийн этгээдээр дамжуулж хэрэгжүүлэх ёстой. Үүнийг би хурлын протоколд тэмдэглүүлж, зээлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

### Нэг тэрбум ам.долларын зээлийг эрчим хүчний салбарт зарцуулна

Манай Улс, БНХАУ-ын Экспорт-Импортын банк хоорон-

### Д.Тэрбишдагва: Зээлийг үр дүнтэй ашиглаж чадахгүй байна

“Сангийн яамныхан надад нэг тайлбар өгөхгүй юу. 2004 оноос хойш БНХАУ-ын буцалтгүй тусламжаар зээл авсан санагдах юм. Тэр зээл хэрэгжихгүй явсаар эдүгээг хүрлээ. Тухайлбал, миний сайн мэдэж буйгаар 2004 онд “Эгийн голын цахилгаан станц”-ын талаар ярьж байсан. 13 дахь жилдээ “Эгийн голын цахилгаан станц”-ын асуудал ороод ирлээ. 2004 онд БНХАУ-

### З.Нарантуяа: Засгийн газрын гадаад, дотоод өр 700 тэрбумаар нэмэгдсэн

“Сангийн яамнаас хоёр зүйлийг тодруулъя. Өнөөдрийн байдлаар Засгийн газрын хэмжээнд гадаад, дотоод зээл, зээлийн хүүгийн дүн 2016 оны зургадугаар сарын 30-аас өнөөдрийн хүртэл хугацаанд хэдэн хувиар нэмэгдэж, буурсан бэ. Надад байгаа мэдээллээр нийт өрийн хэмжээ 2016 оны зургадугаар сарын 30-ны байдлаар 24 их наяд, 250 тэрбум байсан бол өнөөдөр 24 их наяд, 957 тэрбум болж өсчээ. 700 орчим тэрбумаар нэмэгдсэн гэх мэдээлэл байна. Засгийн газрын гадаад зээл гэхэд, нэг тэрбум орчим ам.доллараар нэмэгджээ.

### Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 31 гишүүн дэмжлээ

УИХ-ын чуулганы баасан гарагийн нэгдсэн хуралдаанаар Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, баталлаа. Уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох хуулийн төслийг УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулсан бөгөөд санал хураалтад 45 гишүүн оролцож, 31 гишүүн дэмжсэнээр уг хуулийн төсөл батлагдсан юм. Өнгөрсөн дөрөвдүгээр сард УИХ-д өргөн мэдүүлсэн Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь нийт найман бүлэг 70 зүйл заалтаас бүрджээ. Хуулийн төслийг боловсруулахдаа хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн прокурорын байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим, Прокурорын байгууллагын тухай хуульд заасан зарим нэр томъёог оновчтой болгох, Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд УИХ-д өргөн мэдүүлсэн эрүүгийн хууль тогтоомжийн төслүүдтэй уялдуулах, прокурорын байгууллагын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг харьцуулан дүгнэж, үйл ажиллагааны хариуцлагатай байдлыг хангах, бусад байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн үндсийг бий болгох, прокурор үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгааг дээшлүүлэх, албан үүргээ биелүүлэгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо ээргийг тодорхой зохицуулж боловсруулсан байна. Тус хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны долдугаар сарын 1-нээс хэрэгжих ажээ. Энэ мэтчлэн хэд хэдэн хуулийн төслийг баталснаар УИХ-ын баасан гарагийн нэгдсэн хуралдаан өндөрлөлөө.

### Х.Баттулгын штабтай 90991206 шууд утсаар холбогдоорой

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа эхэлсэнтэй холбогдуулан АН-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн штаб шууд утас ажиллуулж эхэллээ. Иргэддээ ойр байх, иргэдийнхээ санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, санал бодлыг нь бодлого шийдвэртээ тусгах зорилгоор АН өмнө нь 1206 шууд утсыг ажиллуулж байсан бол энэ удаа сонгуулийн сурталчилгаатай холбогдуулан 90991206 шууд утас ажиллуулан, иргэдтэйгээ холбогдож байна. Иргэд сонгуулийн сурталчилгаатай холбоотой аливсаа санал, гомдол, зөрчлийн талаар энэхүү утсаар мэдээлж болох бөгөөд Сонгуулийн тухай хуулийн талаар шаардлагатай зөвлөгөө мэдээллийг авах боломжтой юм.

## Г.ЧУЛУУНБААТАР ТАМГАА ХҮЛЭЭН АВЛАА



Гэрэл зургийн Т.АРГУУЖИН

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат БСПШУС-ын сайдад Г.Чулуунбаатарыг томилуулах санал оруулсныг УИХ-ын чуулганы үдээс өмнөх нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн 94.2 хувь нь дэмжин түүнийг БСПШУС-ын сайдаар томилсон билээ. Тэгвэл ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат БСПШУС-ын сайд Г.Чулуунбаатарт тамгыг нь хүлээлгэн өглөө. Өнгөрсөн 14 хоногийн хугацаанд Засгийн газрын тухай хуулийн дагуу ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат

БСПШУС-ын сайдын үүргийг түр хавсран гүйцэтгэж байсан юм. Энэ үеэр ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат “Хэдийгээр хариуцлага алдсан хэмээн салбарын сайд нь огцорсон боловч өнгөрсөн хугацаанд өрнөсөн бүх асуудал ганц сайдын буруугаас болоогүй. Үүнийг БСПШУС-ны бүх ажилтан, албан хаагч, дарга, удирдлагууд дор бүрнээ сайтар тунгааж бодоорой. Салбарын сайд огцорсноор асуудал шийдэгдэхгүй. Тиймээс шат, шатандаа хариуцлага тооцох асуудал байгаа гэдгийг анхаараарай. Ажлаа хүлээж авсан сайд та Монгол Улсын зүрх, тархи болсон хамгийн чухал салбарт алдаа, дутагдал гаргалгүйгээр хурдтай, ёсзүйтэй, хариуцлагатай

ажиллахыг хүсье” гэв. Харин БСПШУС-ын сайд Г.Чулуунбаатар “Миний ажил асуудлыг оношлохоос эхэлнэ. Өөрөөр хэлбэл, БСПШУС-ны дотор болон гадна өрнөж буй үйл явдал, алдаа дутагдал, болохгүй байгаа асуудал юунаас эхтэй вэ гэдгийг оношлохоос эхэлнэ. Гэхдээ зөв оношлох хэрэгтэй. Түүний дараа хариуцлагын асуудал яригдана. Боловсрол, шинжлэх ухааны салбарт олон жил ажилласан хүний хувьд би энэ салбарыг гадарлана. Гэхдээ багш, судлаач байх нь төрийн бодлогыг хэрэгжүүлэхээс ялгаатай ажил юм. Тиймээс баг, хамт оныхоо тусламж, дэмжлэгтэйгээр сайн ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна” гэлээ.

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

**Э.САЙНЗАЯА 99197866**

Дугаарыг эрхэлсэн **Б.ӨНӨРТОГТОХ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар. 209, 211 тоот**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, Чөлөөт хэвлэл сан-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

# ТЭД ЮУ АМЛАВ

Дугаарын **60** мөр

Хот  
үмхийрлээ

Үргэлжлэл.  
Турүүч нь 1 нүүрт

Тэгээд “Төв цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, хөрөнгө оруулалтын асуудал”-аар хэлэлцүүлэг зохион байгуулж байлаа. Үүний үр дүнд энэ дөрвөн жилд Төв цэвэрлэх байгууламжийг барьж дуусгах юм байна гэдэг мессежийг тухайн үед хэвлэлээр дамжуулан олон нийтэд хүргэсэн. Олны хэл амыг дарж, түр ч атугай “гал унтраах” энэ аргыг үе үеийн дарга нар хэрэглэсээр л.

Харин өнгөрсөн жил Ази Европын чуулга уулзалт Монголд болж, нийслэлийн иргэд Төв цэвэрлэх байгууламжийн үмхий үнэрийг ганц зун ч гэсэн мартаж билээ. Учир нь АСЕМ-д ирсэн дээд хэмжээний хүндтэй зочдыг Улаанбаатар хот үмхийрч, бохиртойгоо хутгалдсан байдалтайгаар утгахыг хүсээгүй юм. Тэгээд төд удалгүй намрын сэрүү орж, өвлийн жаварт өнөө үнэр ташар түр мартагдсан хэрэг. Гэтэл одоо зун болдоогоороо болж, цэвэрлэх байгууламжийн асуудал дахин сохогдож байна.

Өнгөрсөн зун үмхий үнэрийг үнэтэй бодисоор дарж байжээ. Энэ ажилд улсын төсвөөс 8.1 тэрбум төгрөгийг зарцуулсан юм байна. Харин энэ жил хэт зардал өндөртэй энэ аргаас татгалзсан бололтой.

Бүхэл бүтэн улсын нийслэл бохироороо амьсгалж байна. Өөрөөр хэлбэл, хот үмхийрлээ. Эсвэл үмхийрч л байж юм уу. АСЕМ-гүй хотын ард иргэд зуны нарлаг сайхан өдрүүдэд бохироороо амьсгалах шийтгэл хүлээгээгүй л байлтай. Тиймээс энэ дөрвөн жилдээ багтаан Төв цэвэрлэх байгууламжийг барьж дуусгана гээд “ам гарчихсан” юм чинь түр зууртаа буюу үлдсэн хоёрхон жилд АСЕМ-аар хэрэглэсэн арга ард түмнийхээ төлөө хэрэглэж болохгүй юу. Зардал мөнгө нь ч арай бага орох байлгүй дээ. Өмнө нь зарцуулсан 8.1 тэрбум төгрөгөөр Төв цэвэрлэх байгууламжаас гарах үнэрийг дарах технологийг сайжруулах 25 ажил хийсэн гэж танилцуулж байсан. Харин одоо технологи нь сайжирсан юм бинь зөвхөн бодисоо худалдаад авчихгүй юу. Харин халаа сэлгээ хийж, мэргэжлийн хүмүүсийг ажлаас халахгүй байх тухай асуудлыг өнгөрсөн хавар хөндөж байсан. Энэ нь ч аргагүй биз. Бодлогын төвшинд дорвитойхон ажил хийсэн шиг хийлгүй түр зуур аргацааж, дарга нар хотынхоо бохирьг цэвэрлэх ажлыг бие бие рүүгээ шидэж өнгөрөөх гээд байдаг нь гэм биш зан. Тэгсэн атал мөрөөрөө ажлаа хийж яваа эгэл жирийн иргэн хүнтэй хатуу чанга хариуцлага тооцон сүрийг бадруулж, ажил амьдралаар нь хохироодог жиниг манайд тогтоод буй нь хэдийн ил тод болжээ. Тэгээд ч зөвхөн үнэрээр нь амьсгалахад нийм хүнд байгаа юм чинь тухайн орчинд буюу яг голомт дээр нь ажиллахад ямар хэцүү байх вэ гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Тиймээс Төв цэвэрлэх байгууламжид ажилладаг хүмүүс 45 нас хүрээд тэтгэвэрт гарахаар болжээ. Мөн ажлын орчныг хүнд хортой гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна.

Төв цэвэрлэх байгууламжид ажиллаж буй иргэдийн шийдвэрлэх эхэлсэн нь сайшаалтай. Одоо харин Төв цэвэрлэх байгууламжаа барих ажлаа түргэвчилмээр байна. Үгүй ядаж л 1.5 сая хүн холхөж буй бүхэл бүтэн улсын нийслэл байна даа, баригдаж дуусах хүртэл нь үнэр танараа дарах арга чарга авахгүй бол арай л биш ээ.



**“Хүчирхэг монгол” ба эх оронч Ерөнхийлөгч**

## “Хүчирхэг монгол” ба эх оронч Ерөнхийлөгч

АН-аас нэр дэвшигч Х.Баттулгын тухайд “Монгол ялна” гэсэн өвөрмөц уриаг дэвшүүлсэн. Энх цагт дайн байлдааны тухай ярихгүйгээс хойш энэ үгээрээ нэр дэвшигч тун олон зүйлийг хөндөхийг хүсчээ. Хамгийн нэгдүгээрт, эдийн засгийн хувьд хэн нэгнээс, аль нэг улсаас хараат байдал оруулахгүйн төлөө энэхүү уриаг гол болгосон аж. Цаашлаад, өдөр өдрөө алсарч буй үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолоо хамгаалах, бусдад түүхийг эд бэлтгэн нийлүүлэгч бус, өөрсдөө үйлдвэрлэдэг, баялаг бүтээдэг, нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн гаргадаг байхыг “Монгол ялна” гэж үзэж байгаагаа нэр дэвшигч нээлттэйгээр үгээр ойлгож удаатай. Х.Баттулга нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр тун энгийн, ойлгомжтой. Хэтэрхий их нуруаагүй өмнө хэлсэнчлэн, эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого, монгол хүн гэсэн үндсэн сэдвийн хүрээнд бодлогын ямар томоохон ажил хийхээ таван сэдвээр багцлан бэлтгэжээ. Эв нэгдлийг эрхэмлэх тухай дэд хэсэгт талцал хуваагдлыг арилгаж, нийгмийн бүх хэсэгт байгаа зөрчил, талцал хуваагдал, үгүйсгэх, гутаах, тэмцэлдэх байдлыг арилгана хэмээжээ.

Мөн үндэсний аюулгүй байдлаа хамгаалах, улс орнуудтай найрсаг хамтын ажиллагааг чухалчлах, үндэсний хэл соёл, өв сангаа хайрлаж хамгаалсан Ерөнхийлөгч байхаа амалсан байв. Мөрийн хөтөлбөрийн хоёрдугаар хэсэгт, эрх чөлөө, шударга ёсны тухай асуудлыг тусгажээ. Энэ хэсэгт төрийн алба, хууль шүүхийн байгууллагын хараат бус байдал, хэвлэл мэдээллийн чөлөөт байдал, боловсрол, эрүүл мэндийн асуудлыг тусгасан аж. Тухайлбал, иргэн бүр хууль шүүхийн өмнө адил тэгш байх шүүхийн шинэчлэлийг үргэлжлүүлэхээс гадна төрийн албаны хүнд суртлыг арилгаж, сонгогдсон болон томилогдсон албан тушаалтнуудын хариуцлагын асуудлыг ч анхаарлаас гадуур орхихгүй хэмээжээ. Хэвлэл

мэдээллийн бие даасан байдлыг хүндэтгэх, иргэний мэдэх эрхийн төлөө дуугардаг Ерөнхийлөгч байх гэнэ. Монгол хүнээ дэмжих тухайд үндэсний бахархал болсон контентийг дэлхий дахинд түгээх, монгол хүн бүрийн хийсэн бүтээснийг зөвшүрдугаар үнэлдэг байхаас гадна мэргэжлийн боловсрол эзэмшсэн залуусаа дэмжих тухай ч тодорхой санал тусгажээ. Шагналын тухайд ч тэр цензуртэй Ерөнхийлөгч байх нь. Үүнээс гадна иргэд эрүүл мэндийн даатгалаар дан ганц эмнэлгийн үйлчилгээ авах бус спорт төвүүд, фитнес клубээр үйлчлүүлэхдээ ч үйлчилгээ авч болох тухай нэр дэвшигч Х.Баттулга мөрийн хөтөлбөртөө онцолсон нь юу юунаас илүүтэй анхаарал татлаа. Халамжийн хөтөлбөрийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ чиглүүлэх бол, эх хүүхдийг дэмжих чиглэлд илүү олон ажил хийхээр тусгажээ. Тухайлбал, олон хүүхэдтэй айл өрхийг орон сууцжуулах, “цалинтай ээж” зэрэг хөтөлбөрийг дэмжиж ажиллахаа илэрхийлсэн байв. Өрх толгойлсон, бага орлоготой, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүүхдийг дэмжих, харьяалал харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хамруулах асуудлыг ч мөн онцолсон байна. Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт эдийн засгийн асуудлыг тун тодорхой, дэлгэрэнгүй тусгажээ. Тухайлбал, эдийн засгийг олон тулгууртай, өрсөлдөх чадвартай болгох гарц нь аж үйлдвэржилт гэж үзжээ. Тэр ч утгаараа, аж

үйлдвэрийн хөгжлийг дэмжих банк санхүү, хөрөнгийн зах зээл хөгжүүлэх, аж үйлдвэрийн бүтцийг зохиомжлох, эрдэс баялгийн салбарт үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын чухалчлах, аж үйлдвэрээр дамжуулан дундаж орлоготой иргэддээ дэмжих, Монгол Улсад ган хайлуулах, эс хайлуулах болон нефть химийн үйлдвэр бүхий аж үйлдвэрийн парк байгуулах, түүнийг дагасан боловсруулах болон хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх аж үйлдвэржилтийн хөрөнгө оруулалт, мегатөслүүдийг дэмжих гэх мэтээр үйлдвэржилтийн шинэ үеийг эхлүүлэх Ерөнхийлөгч байна гэж амлажээ. Түүний дараа дараагийн дэд сэдвүүд байгаа орчин, экспортыг дэмжих, гадаад харилцааг бэхжүүлэх чиглэлд бий. Хоёр хөрштэйгээ найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлж, хоёр хөршийг холбосон эдийн засгийн бүс (коридор)-ийг хөгжүүлнэ гэж амласан байна. Мөн эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийг түргэсгэж, гуравдагч хөрш орнуудтай ч эрх тэгш харилцааг Ерөнхийлөгч байна гэв. Түүнд эх орноо гэсэн сэтгэл бий. Хөгжүүлэх хүсэл зорилготой гэдгээ ч олонтой харуулсан. Нөгөөтэйгүүр, жирийн л баялаг бүтээгчдийн нэг. Тэр ч утгаараа аж үйлдвэрийн шинэ эрин үеийг эхлүүлж чадна гэх итгэл олон хүнд бий. Монгол төрд нэг нам ноёлсон энэ үед сөрөг хүчний Ерөнхийлөгчтэй байх нь олон талаар давуу байж мэдэх билээ.



**М. Энхболд: Би Ерөнхийлөгчөөр сонгогдвол монгол төрийн бодлогын залгамж чанарыг өвлөн харгааж, нийгмийн бүлэгүүдийн оролцоо, саналыг хүндэтгэн хангаж, УИХ, Засгийн газартай гэр нийлэн, хүч хавсарч энэхүү мөрийн хөтөлбөрөө биелүүлэх болно.**

## Монгол гэр-Монгол төр

МАН-аас нэр дэвшигч М.Энхболдын тухайд “Эвтэй монгол-Ээлтэй төр” уриаг дэвшүүлсэн. Иргэндээ ээлтэй төр, дотоод гадаадаа ч эв тунжинтэй байх гэдэг утгаар энэхүү уриаг дэвшүүлсэн юм билээ. Тэгвэл М.Энхболд нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр үндэсний уламжлалаа дээдлэх үүднээс “Монгол гэр”-ийн загвараар бүтээгдэжээ. Гэвч доторх санаа нь Ерөнхийлөгчийн хувиар тийм асуудлыг тэгж шийдэж, өөрчлөлт шинэчлэлт хийнэ гэхээс илүү Засгийн газрын бодлого шийдвэрийг дэмжиж ажиллана гэсэн хэт ерөнхий, бөөрөнхий утгатай заалтууд их байх юм. Монгол Улсын тэргүүний хувиар бус намын даргын үүднээс мөрийн хөтөлбөр боловсруулсан гэх шүүмжлэл ч үнэний ортой дуудаж байв. Монгол гэрийн тооно нь үндэсний эв нэгдэл, монгол бахархал. Энэ хүрээнд нэр дэвшигч улс төрийн намуудын хариуцлага, хэвлэл мэдээлэл буюу дөрөвдөгч засаглалтай харилцах харилцаа, бүлэглэлүүдэд бус иргэдэд үйлчилдэг Ерөнхийлөгч байх тухай асуудлыг тусгажээ. Харин хана буюу хариуцлагатай, шударга,

тогтвортой засаглалын тухайд төрийн алба, Үндсэн хууль, авлигын асуудлыг чухалчлсан аж. Тухайлбал, Үндсэн хуулийг ард түмнээсээ асууж өөрчилнө гэв. Төрийн албаны хариуцлагыг чангатгаж төрийн албанд авлигын хэрэгт нэр холбогдсон хэнийг ч ажиллуулахгүй гэж тусгажээ. Хууль шүүхийн байгууллагын хяналтыг сайжруулж шүүхийн байгууллагад улс төрийн оролцоо байхгүй болгохын төлөө ажиллахаа М.Энхболд амлажээ. Мөрийн хөтөлбөрийн урьд хэсэг нь “Монголхун”. Тэгвэл монголхунээ хөгжүүлэх чиглэлд М.Энхболд нэр дэвшигч боловсрол, эрүүл мэнд, гадаадад сурах боломж,

нийгмийн халамжийн үйлчилгээ авах асуудлаар ангилсан байх юм. Эрүүл мэндийн чиглэлд түүний амлалт тун хомс. Харин урьдчилан сэргийлэх чиглэлд хөтөлбөр боловсруулах юм байна. Залуусыг гадаадад сургах боломжоор хангахаас гадна дэлхийн боловсролыг эх орондоо авах боломжийг хангах Ерөнхийлөгч байхаа амлажээ. Цаашлаад, өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ халамжилдаг, малчдаа урамшуулдаг, багш, эмчийн үнэлэмжийг дээшлүүлсэн Засгийн газрын хөтөлбөр бүрийг нэр дэвшигч М.Энхболд дэмжиж ажиллах аж. Түүний мөрийн хөтөлбөрт туссан эдийн засгийн асуудал “багана” бүлэгт оржээ. Тэр дундаж давхаргаа дэмжих нь эдийн засгаа солонгоруулах боломж гэж харсан аж. Х.Баттулга нэр дэвшигч аж үйлдвэр буюу бүтээн байгуулалт гэж харсан бол М.Энхболд нэр дэвшигч иргэнээ дэмжихийг эдийн засгаа солонгоруулах боломж хэмээн харсан байх юм. Улмаар гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, итгэлийн нь сэргээснээс эдийн засгаа эмнэлгээс гаргаж, богино хугацаанд хямралыг цэгцлэх амлалт өгчээ. Түүний мөрийн хөтөлбөрт гурван улсын эдийн засгийн коридорын асуудал ч тусгагдсан байх аж. Цаашлаад, уул уурхайн баялгаа эцсийн бүтээгдэхүүн болгох, аж үйлдвэрийн парк байгуулах гэх мэт бидний олон жил ярьж буй,

намуудын байнга шахуу өгдөг амлалтуудыг тэрбээр жагсаажээ. Оффшор бүсэд данстай байхыг зөвшөөрөхгүй, төрийн өмч нь өр үйлдвэрлэхгүй гэх амлалтыг ч тэр өгчээ. Харин ам, ажил хоёр нь алд дэлэм зөрөхгүй байхаасай. Ерөнхийлөгч бүрийн анхаарлаа хандуулдаг байгаа орчин, аюулгүй байдал, гадаад бодлогын асуудал “үүд” хэсэгт оржээ. Өөрөөр хэлбэл, хоёр хөршийн найрсаг харилцаанаас гадна гуравдагч орнуудтай хамтын ажиллагаа өрнүүлэх, олон улсын идэвхтэй хамтын ажиллагаа, визгүй зорчих орнууд нэмэх, уур амьсгалын өөрчлөлт агаарын бохирдолттой тууштай тэмцэхээ амлав. Уул уурхайн нөхөн сэргээлтэд анхаарал хандуулж, эх орноо дэлхийд таниулах амлалтыг М.Энхболд өгчээ. Тэгсгэлд нь энэ бүхнээ Засгийн газартайгаа уялдуулж хийнэ гэх амлалт өгсөн. Гэвч Үндэсний эв нэгдлийн бэлэг тэмдэг гэдэг утгаараа Ерөнхийлөгч хүн намын амлалтыг биелүүлэх байх учиргүй. Нэг нам дангаар ноёлсон Засгийн газар, УИХ-д хариуцлага тооцдог, хяналт тавьдаг, намын гишүүдийн бус ард түмний нүд чих болж ажиллах ёстой учраас УИХ, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг дэмжиж, аялдан дагалдагч бус зөвийг нь сайшааж, харин бурууг нь ил тод хэлдэг зангаргагтай, хүчтэй Ерөнхийлөгч байх учиртай. Тэр харин чадах эсэхийг хэлж мэдэхгүй нь.



**С.Ганбаатар: Монголын ард түмний амин эрх ашиг, Монгол Улсын үндэсний эрх ашиг бол миний хувьд Бурханы зарлиг. Би энэ зарлигийг биелүүлнэ. Эв нэгдлийг эрхэмлэж, эрх чөлөөг баталгаажуулна.**

## Өөр гарц ба “бурханы зарлиг”

МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатарын тухайд “Бидэнд итгэ-Өөр гарц” бий хэмээн уриалав. Өөрөөр хэлбэл, олон жилийн турш хоёрхон намд дарлуулж ирсэн монголчууд МАХН-аас

нэр дэвшигчийг сонговол өөр гарц санал болгох юм билээ. С.Ганбаатар нэр дэвшигчийн Монголоо хөгжүүлэх төлөвлөгөө тун цомхон. Гэхдээ хэт хийрхэн, дэврүүн өнгө аяс ажиглагдах.

Эдийн засгийн хөгжил, үндэсний хэмжээний анхаарал татсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх, ямар гарц байгааг харах гэхээс илүүтэй өнөөх л олон жил ярьсан шударга ёс, оффшор, бүлэглэл гэсэн “поп” өнгө аяс дуудана. С.Ганбаатар нэр дэвшигч байгаа нь бурханы зарлиг гэх мэтийн нэр дэвшигчийн өөрийн нь олон жил хийж ирсэн “барьцгүй” улстөржилт нэвтгүртсэн мөрийн хөтөлбөр болжээ. С.Ганбаатар МАХН-ын гишүүн биш. Тухайн намын нэрийг зээлдэн орж байгаа учраас Засгийн газар, УИХ-ын ийм үйл ажиллагааг тэгж дэмжиж ажиллана гэх амлалт бараг алга. С.Ганбаатар нэр дэвшигч хариуцлагатай засаглалыг бий болгож ажилгүйдэл ядуурлыг арилгах амлалт өгчээ. Монгол залуус эх орондоо ажил хөдөлмөр эрхлэх, талхыг таллаж биш бүтээр нь авдаг улс болгохоор зүтгэх юм байна. Мөн оффшорчдоос төрөө салгаж, олигархиудад хатуу

хандахаа амлав. Гадны оффшор дансанд байршуулсан мөнгийг эх орондоо эргүүлэн авчара ажлыг тэр эхлүүлэх гэнэ. Тэр “Ард Аюуш” шиг тэмцэх бөгөөд есөн эрүү тулгасан ч бууж өгөхгүйгээр шударга ёсны төлөө тэмцэхээр амлажээ. Үүнийг бурханы зарлиг хэмээн хүлээж авснаа онцолсон байв. Энэ мэтээр бодлогын гэхээс илүүтэй хэтэрхий сэтгэлийн хөөрлөөр хандсан, зүгээр л нэг гудамжинд тэмцэхдээ үг хэлж байгаа аятай бичсэн мөрийн хөтөлбөрөөс тэр, энэ гэж онцлохоор зүйл гарсангүй. Ерөөс түүний амлалтыг тоймлолвол эх орондоо эзэн байх, хариуцлага, шударга ёсыг төрөөс нэхэх, хулгайч улстөрчидтэй хатуу тэмцэх нь гэж ойлгогчид гэмгүй. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах нь ард түмний халааснаас идэж ууж буй авлигачдыг цөөрүүлснээр бий болно гэж С.Ганбаатар үзжээ. Авлигыг үгүй болгож, төрд суугаа луйварчдаас салчихвал Монголын эдийн засаг сэргэх аж.

## УЛС ТӨР

ТОМИЛОЛТ



## ШХАБ-ЫН ШИНЭ ТҮҮХ АСТАНАГААС ЭХЭЛЛЭЭ

С.ГАН

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж бүрэн эрхийн хүрээнийхээ хамгийн сүүлийн албан ёсны томилолтыг Бүгд найрамдах Казахстан улсын нийслэл Астана хотод хийлээ. Тодруулбал, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд оролцоод өчигдөр эх орондоо ирсэн юм. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 17 дахь удаагийн өргөтгөсөн хуралдаанд ажиглагчийн хувиар оролцлоо. Монгол Улс нь Ази-Номхон далайн бүс нутагт өрнөж байгаа улс төр, эдийн засгийн үйл явцад идэвхтэй оролцох гадаад бодлогын зорилтын хүрээнд ШХАБ-ын бүс нутгийн олон талт хамтын ажиллагаанд оролцох нэг чухал суваг гэж үзэн 2004 онд тус байгууллагад ажиглагчийн статустай болсон байдаг. Ажиглагчийн статустай болсон үеэсээ Монгол Улс ШХАБ-ын гишүүн орнуудын төр, засгийн тэргүүн нарын уулзалтад тогтмол оролцохыг эрмэлзэж ирсэн билээ. Төрийн тэргүүн энэхүү айлчлалын үеэр “Астана-Экспо-2017” олон улсын үзэсгэлэнгийн албан ёсны нээлтийн арга хэмжээнд оролцлоо. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага нь анх “Шанхайн тав” гэж 1994 онд байгуулагдсан бөгөөд хожим 2001 онд Узбекистан улс нэмэгдэж, ШХАБ гэж нэрлэж байжээ. Тус байгууллагын хамгийн гол зорилго нь гишүүн улсуудыг нэгтгэж байгаа өргөн уудам орон зайд аюулгүй тогтвортой байдлыг бэхжүүлэх явдал бөгөөд алан хядаж ажиллагаа, мансууруулах бодисын суваг болон хэт даврах, салан тусгаарлах үзэлтэй тэмцэх, эдийн засгийн хамтын ажиллагаа, эрчим хүчний түншлэл, шинжлэх ухаан, соёлын харилцан хамтын ажиллагааг хөгжүүлэх билээ. Түүнчлэн, үйл ажиллагаанд нь Афганистан, Беларусь, Энэтхэг, Иран, Монгол, Пакистан гэсэн ажиглагч зургаан орон, түүнчлэн Азербайжан, Армени, Камбож, Балба, Турк, Шри-ланка гэсэн яриа хэлэлцээний түнш орнууд оролцдог юм.

Ц.Элбэгдорж: ОХУ, БНХАУ-тай хамтын ажиллагааг өргөжүүлэх нь манай улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл

Өнгөрөгч баасан гарагт Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд үг хэлвэ. Түүний хэлсэн үгийг бүрэн эхээр нь хүргэе. Ерөнхийлөгч хэлсэн үгэндээ “ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг зохион байгуулж байгаа Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Н.Назарбаев танд болон танай Засгийн газарт гүн талархал илэрхийлэе. ШХАБ-д бүрэн эрхт гишүүнээр элссэн Энэтхэг, Пакистан Улсын төлөөлөгчдөд чин сэтгэлийн баяр хүргэе. ШХАБ гишүүнчлэлийн хувьд ийнхүү өргөжин тэлж байгаа нь түүний улс төр, эдийн засгийн нооц боломж, олон улсын нэр хүндийг өсгөж, бүс нутгийн тулгамдсан асуудал, сорилтуудыг шийдвэрлэхэд шинэ эрч хүч өгнө гэдэгт итгэлтэй байна. Монгол Улс ШХАБ-д ажиглагчаар элссэнээс хойш тус байгууллагын гишүүн орнуудын төр, засгийн тэргүүн нарын болон бусад уулзалт, арга хэмжээнд тогтмол идэвхтэй оролцож, хувь нэмрээ оруулахаар чармайж ирлээ. Манай улс ШХАБ-ын өргөжин тэлэх үйл явц, хөгжил дэвшил, цаашдын төлөв байдлыг анхааралтай ажиглан харж



байна. Гишүүн болон ажиглагч орнуудын хоорондын харилцааг зохицуулах эрх зүйн орчныг сайжруулж, хамтын ажиллагааг эдийн засгийн бодит агуулгаар баяжуулах нь чухал юм” гэв. Мөн энэхүү уулзалтын үеэр Монгол Улсын ашиг сонирхол хаашаа чиглэж байгаа, гадаад бодлогын тэргүүлэх чиглэл юм. Монгол Улсын санаачилгаар Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын уулзалт болон гурван талын хамтын ажиллагааны бусад механизм

бүрдэж, амжилттай ажиллаж байна. Монголын “Хөгжлийн зам” хөтөлбөрийг Хятадын “Бүс ба зам” санаачилга болон ОХУ-ын Евроазийн эдийн засгийн холбоо, хамтын ажиллагааны механизмтай уялдуулан Монгол Улсын нутаг дэвсгэрээр эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт бид онцгой анхаарал тавьж байна. Монгол Улсын нутаг дэвсгэрийг дайруулан ОХУ, Европ болон БНХАУ, Азийн холбоосон хамгийн дөт, хамгийн аюулгүй, хамгийн хялбар, хамгийн хямд дэд бүтцийг барьж байгуулах боломжтой. Эдгээр төсөл, хөтөлбөр хөрөнгө оруулагчдад томоохон орон зай нээх тул ШХАБ-ын үйл ажиллагаанд оролцож улс орнуудыг идэвхтэй дэмжин оролцохыг уриалж байна. Манай улс анхдагч эрчим хүчний нөөц ихтэй орны хувьд хөрш орнуудтайгаа эрчим хүчний дэд бүтцийн холбоог хөгжүүлж,

харилцан ашигтай хамтран ажиллах бодлого баримталж байна. Манай орон нар, салхи, усны зэрэг сэргээгдэх эрчим хүчний арвин их нөөцийг түшиглэн Ази, Номхон далайн бүс нутгийн эрчим хүчний системд нэгдэхэд чиглэсэн үр ашигтай, байгаль дэлхийд ээлтэй төслүүдийг хамтран хэрэгжүүлэхийг та бүхэнд уриалж байна” хэмээлээ. Харин хамтын ажиллагааны хүрээнд илэрхийлсэн байр суурьтай “Бид ШХАБ-ын хүрээнд шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, гамшигтай тэмцэх, ХАА зэрэг салбарт хамтран үйл ажиллагаа явуулахыг эрмэлзэж байна. Түүнчлэн соёл, урлаг, спортын олон улсын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь ард түмнүүдийн харилцан ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлж, бүс нутгийн эдийн засгийн томоохон төсөл, санаачилгуудыг амжилттай хэрэгжүүлэх үндэс суурь болно гэж үзэж байгаа. ШХАБ үйл ажиллагааны хувьд ч өргөжиж, аюулгүй байдал, худалдаа, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбар зэрэг олон талт хамтын ажиллагааг хамарсан байнгын ажиллагаатай олон улсын байгууллага болж өсч өндийж буйд баяртай байна. Манай үйл ШХАБ-тай терроризм, хар тамхины хууль бус наймаатай тэмцэх чиглэлд хамтран ажиллахыг мөн сонирхож байна. Мансууруулах бодистой тэмцэх ШХАБ-ын стратегийг энэхүү хуралдаанаар хэлэлцэн баталсныг бид сайшаан дэмжиж байна. ШХАБ-ын үйл ажиллагаанд оролцогч улс орнуудын хувьд үйл ажиллагаагаа бэхжүүлж, харилцан уялдаа холбоогоо сайжруулах нь Монгол Улсын хөгжил дэвшилд чухал ач холбогдолтой төдийгүй, дэлхий нийтийн энх тайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна. Анхаарал тавьсанд баярлалаа” хэмээн онцлолоо.

Астана таван сая зочин хүлээж авна гэв

Хамтын ажиллагааны уулзалтын дараа өнгөрөгч бямба гарагт Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Астана Экспо-2017” үзэсгэлэнгийн албан ёсны нээлтийн арга хэмжээнд оролцлоо. Бүгд Найрамдах Казахстан Улс нь Олон улсын үзэсгэлэнгийн төвчоноос “Дэлхийн Экспо” үзэсгэлэн зохион байгуулах эрхийг 2012 онд авсан бөгөөд тус улсын Ерөнхийлөгч Н.Назарбаев 2014 онд Монгол Улсыг тус үзэсгэлэнд оролцохыг урьжээ. Уг үзэсгэлэн “Ирээдүйн эрчим хүч” сэдвийн хүрээнд албан ёсоор энэ оны зургадугаар сарын 10-наас есдүгээр сарын 10-ны хооронд болох юм байна. Экспо дэлхийн 100 гаруй улс орон, олон улсын 20 орчим байгууллагын төлөөлөл оролцож байгаа аж. Арга хэмжээний хүрээнд 20 гаруй сэдвээр бизнес форум, үндэсний өдөрлөг, урлаг соёлын арга хэмжээнүүд

болох ажээ. Ирэх гурван сарын хугацаанд нийт таван сая зочин хүлээн авахаар төлөвлөсөн байна. Үзэсгэлэнгийн бэлтгэл ажилд 1.5 тэрбум ам.доллар зарцуулжээ. Үзэсгэлэнгийн нийт талбай 303000 кв.м бөгөөд Назарбаевийн нэрэмжит их сургуулийн ойролцоо, Астана хотын шинэ төвд байгуулагдажээ. Энэхүү шинэ төвийг “Ехро-2017” олон улсын үзэсгэлэн өндөрлөсний дараагаар Казахстан улс “Шинжлэх ухаан, технологийн парк” болгох төлөвлөгөөтэй ажиллаж байгаа аж. Сонирхуулахад, 2012 онд энэхүү үзэсгэлэн нь Өмнөд Солонгос улсад, 2015 онд Итали улсад тус тус зохион байгуулагдаж байжээ.

Д.Баярхүү: Гурван талт уулзалт улстөржилтөөс бус мөчлөг дууссан учраас болсонгүй

Гадаад харилцааны салбарт олон жилийн турш ажиллаж буй гадаад бодлогын эксперт Д.Баярхүү ШХАБ-ын 17 дахь удаагийн дээд төвшний уулзалтын талаарх ажиглалт дүгнэлтээ сэтгүүлчидтэй хуваалцлаа. Тэрбээр, “Монгол Улс бол ШХАБ-ын анхны ажиглагч гишүүн. Ажиглагчийн статустай дөрвөн улс байдгийн нэг нь. Монгол Улсын хувьд Шанхайн хамтын ажиллагааны байгууллага бол хамтын ажиллагаа гэдэг утгаараа манай улсын хөгжил дэвшлийн гадаад таатай орчныг бүрдүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, тэр дундаа “Эдийн засгийн коридор”-ыг байгуулахад ач холбогдолтой юм. ШХАБ-ын хэлэлцэж буй цэрэг, улс төр, аюулгүй байдлын асуудал нь Монголын хувьд тулгамдсан асуудал биш юм. Түүнчлэн ШХАБ-ыг даргалж буй Казахстаны хувьд ч мөн адил хамтын ажиллагаа чухал гэж үздэг. Харин ОХУ-ын хувьд аюулгүй байдлын асуудал, шинээр гишүүн элсүүлэх асуудлыг илүүтэй хөнддөг байх жишээтэй. ШХАБ-ын ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж буй Рашид Алимовын хэлснээр бол, ШХАБ-ыг өргөтгөж гэж яарахгүй байгаа, энэ бол ерөөсөө туйлын зорилго биш юм. ОХУ-ын хүсч шахах байгаагаар бол Иран улсыг тус байгууллагад гишүүнээр элсүүлэх асуудлыг авч хэлэлцэх, болж өгвөл өргөдлийг хүлээн авах нь чухалд тооцогддог. Үүнийг бусад гишүүн орнууд бүгд санал нэгтгэж өргөжүүлж байгаа гэдгийг ШХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга хэллээ. Монголын хувьд гэхэд, хамтын ажиллагааны энэ байгууллагын ажиглагч болсноос хойш Төр, засгийн тэргүүн нарын төвшинд байнга оролцооор ирсэн” хэмээлээ. Мөн энэ удаагийн уулзалтын үеэр ОХУ, БНХАУ, Монгол Улсын гурван талт уулзалт болно гэсэн хүлээлт байсан ч болоогүй юм. Энэ талаар

судлаач Д.Баярхүү “Монгол, Орос, Хятад гэсэн гурван улсын удирдагчдын уулзалт бол механизм. Энэ механизм нь өөрөө мөчлөгтэй. Гурван уулзалт хийгээд нэг цикл /мөчлөг/ нь дуусч байгаа юм. 2014 онд Душанбе, 2015 онд Уфа, 2016 онд Ташкентад уулзалтууд болоод нэг мөчлөг өндөрлөсөн байна. Энэ гурван уулзалтаар ярьсан хэлэлцсэн, гаргасан шийдвэр хангалттай олон бий. Хамгийн гол нь тэдгээрийг хэрэгжүүлэх ажил хоцорч үлдчихээд байна. Манай улс хөгжил, дэвшлийнхээ зорилтыг хангаад, өр ширнээсээ салаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замд эрчтэй орох аваас энэ асуудлыг нухацтай шийдэх боломж бий болно. Ташкентын уулзалтын үеэр харилцан тохиролцсон 30 гаруй баримт бичиг байгаа. Гурван талт уулзалт болохгүй гэдэг нь улстөрөөс үүдэлтэй асуудал биш, энэ бол мөчлөг дуусч байгаатай холбоотой шийдвэр. Гурван удаа уулзлаа, одоо харин дөрөв дэх уулзалт нь шинэ мөчлөгөөр явах нь зүйтэй гэсэн утгаараа энэ удаад гурван улсын дээд хэмжээний уулзалт болохгүй юм” гэсэн тайлбар өглөө.

Хоёр улсаар эгнээгээ тэллээ

ШХАБ-ын 17 дахь дээд хэмжээний уулзалтыг удирдсан Казахстан улсын Ерөнхийлөгч Нурсултан Назарбаев Астанагийн саммитээс шинэ түүх эхэлж буй уулзалтын үеэр мэдэгджээ. Тэрбээр “Астанагийн саммитээс манай байгууллагын шинэ түүх эхэллээ. Зургаан талд томьёоллоор хуралдаан сүүлийн удаа болж байна. Өнөөдөр бид Энэтхэг, Лалын бүгд найрамдах Пакистан улсыг хүлээн авах процедурыг дуусгаж, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын статус олгох шийдвэрт гарын үсэг зурахаар тохиролцлоо” хэмээжээ. Шинэ гишүүдийг хүлээн авах нь байгууллагыг хөгжүүлэхэд хүчтэй түлхэц болох төдийгүй олон улс дахь нэр хүндийг дээшлүүлэхэд дэмжлэх болох ажээ. Мөн тэрбээр дээд хэмжээний уулзалтад оролцогчид олон улсын терроризмийн эсрэг хамтран тэмцэх, хэт даврах үзлийг сөрөн зогсох конвенцид гарын үсэг зурахаа төлөвлөж байгаа гэж онцолжээ. Тэгвэл Энэтхэгийн Ерөнхий сайд энэхүү үйл явдалтай холбогдуулан Астана хотноо БНХАУ-ын тэргүүн Си Зиньпингэй уулзах үедээ ШХАБ-д тус улсыг элсэхэд дэмжлэг үзүүлэн талархаж байгаагаа илэрхийлсэн байна. Тэрбээр өөрийн твиттер хуудастаа “БНХАУ-ын дарга Си Зиньпингэй уулзлаа. Бид Хятад-Энэтхэг хоёр улсын талаар ярилцаж, цаашид харилцаагаа шинэ шатанд гаргах талаар ярилцсан” гэжээ.

11 баримт бичигт гарын үсэг зурлаа

Энэ удаагийн уулзалтаар 11 баримт бичигт гарын үсэг зуржээ. Эдгээрээс терроризмын эсрэг ШХАБ-ын хэлэлцээр Астанагийн тунхаглалыг хэвлэлүүд онцолж байсан юм. Астанагийн тунхаглалыг энэ сарын 9-нд баталж, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын нэгдсэн хандлагыг тусгасан юм. Тодруулбал, терроризм, хэт даврах үзэлд цохилт өгөх нь ШХАБ-ын аюулгүйн салбар дахь чухал чиглэл болохыг тусгажээ. Түүнчлэн, ШХАБ-ын гишүүн орнуудын ард түмний амьжиргааг сайжруулах нь тус байгууллагын нэн тэргүүний зорилт болохыг тунхаг бичигт заасан байна. Мөн бүс нутгийн соёл, боловсрол, экологийг хамгаалах, шинжлэх ухаан, техник, спорт зэрэг салбар дахь хамтын ажиллагаагаа цаашид эрчимжүүлэн байгалийн гамшигт зохицуулах талаар хамтын ажиллагааг тунхагт багтаажээ.

УЛС ТӨР

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ - 2017

# ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГААР ТОГТНОЛЫН ТӨЛӨӨ ЭХ ОРОНЧ Х.БАТТУЛГА ЯЛНА ГЭВ



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

**Төгсгөл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Нийслэлийн дүүрэг, хороо бүрээс ирсэн 5000 гаруй хүн “Улаанбаатар” паласын гадаа талбай, концертын их танхимыг дүүргэсэн энэхүү нээлтийн үйл ажиллагаанд УИХ-ын гишүүн, Ардчилсан намындарга С.Эрдэнэ, Мэргэжлийн сүмогийн их аварга Д.Дагвадорж, УИХ-ын гишүүн асан Ж.Батзандан, Ц.Оюунгэрэл, Нийслэлийн Ардчилсан намын дарга Д.Баттулга, яруу найрагч Т.Галсан, П.Бадарч тэргүүтэй улс төр, урлаг соёлын төлөөллүүд оролцов. Энэ үеэр УИХ-ын гишүүн Ж.Батзандан “Энэ

танхимд албан ёсоор 3500 хүн багтдаг гэдэг. Тэгвэл өнөөдөр 4000 хол давсан хүн цугларсан байна. Гадаа талбайд үүнээс ч олон хүн цугларсан байна. Ардчиллын дэмжлэг ямар аугаа их байгааг хараад би бахархаж зогсоно. АН-аас энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд хүчирхэг Монголын төлөө, Монгол ялна, Монголоо ялуулна хэмээн Х.Баттулга нэр дэвшиж байгаа юм. Үнэн, Монгол ялах цаг болсон. Монголоо ялуулах цаг болсон гэдгийг та бүхэнд хэлбэ. Зарим хүмүүс асууж байгаа. Монгол ялна гэж юу гэсэн үг юм бэ гэж. Би тэр хүмүүст нэг л зүйлийг хэлдэг. Монгол ялна гэдэг бол худал хуурмаг биш шударга

ёс ялахыг хэлж байгаа юм гэж. Би тэдэнд хэлдэг. Монгол ялна гэдэг бол Монголд гадныхан биш монголчуудын эрх ашиг нэн тэргүүнд тавигдахыг хэлж байгаа юм гэдэг” гэсэн юм. Нээлтийн үйл ажиллагааны индэрл гарч үг хэлсэн олны дундаас эрхгүй анхаарал татсан хүн бол нэр дэвшигч Х.Баттулгын охин Б.Намуун байв. Тэрбээр “Аав минь эгэл борги амьдралаас өөрийн хүчээр өндийн босч өдий хүрсэн нэгэн. Зах зээлийн ороо бусгаа үед хүн бүр хоолтой хонохын төлөө хөлс хүчээ урсгаж байсан. Гэхдээ Ардчилал хүн бүхэнд адил тэгш боломж олгосон. Аав минь энэ л цаг үед илүү алсыг харсан нүүдэл хийж, боломжоо бүрэн

ашиглаж зоригтой хөдөлсний учир өдгөө үйлдвэрлэгч, ажиллогч, бүтээн байгуулагч, эх оронч хэмээн хүндлэгдэж яваа болов уу. Охин үр нь болохын хувьд аавынхаа алсыг харсан холч ухаан, эх орон элгэн олноо гэсэн хоёргүй сэтгэлийг нь биширч, бахдаж явдаг” хэмэв. АН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Х.Баттулгыг очсон газар бүрт “Үндэсний эрх ашгаа дээдэлж, хэн нэгэн эрх мэдэлтэн, аль нэг бүлэглэлд үйлчилдэггүй шударга, эх оронч Ерөнхийлөгч байх”-ыг иргэд, сонгогчид захиж байлаа.

*Ингээд түүнийг дэмжсэн иргэдийн сэтгэгдлийг хүргэе.*



П.Бадарч: Есөн эрдэнийн орныхоо Ерөнхийлөгч нь болоорой

*/Ардын уран зохиолч/*



А.Төмөрсүх: М.Энхболд гэх хүн аймагтаа шинэ сум битгий хэл шинэ жорлон ч барьж өгсөнгүй

*/Төв аймгийн Эрдэнэ сумын иргэн/*



З.Оюунцэцэг: 27 жил МАН засагласан Багахангай дүүрэг Баттулгын барсан шинэ сумаас ч хөгжил муутай байна

*/Багахангай дүүргийн иргэн/*



Н.Соёмбо: Монголд хэрэгтэй бодлогуудыг гаргаж чадах хүн учраас би дэмжинэ

*/Дундговь аймгийн иргэн/*

“Би 3000 гаруй хүн суугаад Ерөнхийлөгчөө дэмжиж байгаа уулзалтад анх удаа оролцож байна. Өнгөрсөн нэг жил би гэртээ хэвтрийн дэглэм сахисан. Гэтэл сайхан Баттулга хүү, Лхагвасүрэн жанжин хоёр намайг дуудаж, “Монгол тулгатны 100” эрхэм нэвтрүүлэгт оролцуулж, байцаасан. Гэхдээ их зөв байцаасан. Буруу байцавал би дургүй байж чадах хүн шүү дээ. Би 50 гаруй жил шүлэг бичсэн хүн. Миний хамгийн алдартай шүлэг бол “Есөн эрдэнийн орон”. Х.Баттулга хүү минь Есөн эрдэнийн орныхоо Ерөнхийлөгч болохгүй бол тэр засаг чинь болохоо байлаа шүү. Зөв ажиллаж, зөв яваарай. Дахин дахин амжилт хүсье.

Төрж өссөн Эрдэнэ сумын маань нутагт Чингис хааны морьт хөшөө, 13 дугаар зуун аялал жуулчлалын цогцолбор, Түмэн хишигтэн цогцолбор гээд их бүтээн байгуулалт өрнүүлж өгсөн танд талархаж байна. Өнөөдөр тантай өрсөлдөж буй, Төв аймгаас үеийн үед сонгогдсон Миезгомбын Энхболд гэх хүн бидэнд, Төв аймагчуудад шинэ сум битгий хэл шинэ жорлон ч барьж өгсөнгүй ээ. Залуу хүний хувьд танаар бахархаж, хүндэлж явдаг. Монгол эрчүүд, монгол аавууд, монгол залуучууд тань шиг байгаасай гэж хүсдэг. Тэгж чадвал улс орон минь богино хугацаанд өндөр хөгжилтэй, үйлдвэрлэгч орон болж чадна. Хэн нь хийж бүтээдэг, хэн нь хий хоосон ярьдагийг цаг хугацаа харуулсан, цаашдаа ч харуулна байх.

“Би Багахангай дүүрэгт хэдэн жилийн өмнө шилжиж ирсэн. Улаанбаатар хотын нэг дүүрэг болохоор хөгжил сайтай гэж бодсон. Гэтэл Х.Баттулга нэр дэвшигч таны байгуулсан шинэ сумуудаас чинь хөгжил муутай газар байсан. Одоо ч хөгжихгүй л байна. Энд МАН-ынхан ажилтай байдаг. АН-ынханд ажил олддоггүй. Ардчилсан хувьсгал ялаад 27 жил болж байхад энэ дүүрэгт АН нэг ч удаа засаг барьж байгаагүй. Тийм учраас АН-ын гишүүд маань сэтгэл дундуур, гундуу байдаг. Тийм ч учраас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж байгаа Х.Баттулга нэр дэвшигч АН-ын ялалтын буухиаг эхлүүлж өгөх байх гэж итгэж байна.

“Монгол ялна” гэсэн уриатай болохоор хүмүүс ёжиж байгаа харагдсан. Гэтэл өнөөдрийг хүртэл бид өнөөдрийг хүртэл юун дээр ялав. Эдийн засаг, аж үйлдвэрийн салбарт ялагдсан. Энэ салбарт бодлого урагшаа явахгүй байгаа. Х.Баттулга нэр дэвшигч арьс, шир боловсруулах үйлдвэрийн төслийг сайд байхдаа санаачилж, ажил хэрэг болгох гэж зүтгэж байсан. Монгол Улсад том арьс, шир боловсруулах үйлдвэр ашиглалтад орох нь дээ гэж баярлаж байлаа. Гэвч энэ төслийг эрх мэдэлтнүүд хүчээр зогсоосон. Өнөөдөр арьс, шир ямар үнэтэй байгаа билээ. Хэдхэн мянган төгрөгний л үнэтэй байна. Гэх мэт олон зүйл дээр бид ялагдсан. Энэ хэцүү цаг үед Монголд хэрэгтэй тэр бодлогуудыг энэ хүн л гаргаж чадна гэдэгт итгэлтэй байна. Тийм болохоор бид дэмжинэ ээ.

# АЯНЫ БОГЦ

АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

## Си Зиньпиний НУТГААР...

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Хөгжил цэцэглэлтээрээ Шанхайн дараа бичигдэхүйц далайн эргийн хотыг яагаад ч юм Ховд аймагтайгаа зүйрлэмээр санагдсан. Тодруулбал, Хан Жо нь БНХАУ-ын дарга Си Зиньпиний нэгэн цагт ажиллаж амьдарч байсан хот. Ховд аймаг бол Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн төрж өссөн нутаг. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн урилгаар урд хөршид айлчлахдаа замын турш хоёр улсын төрийн тэргүүний нутаг усаа гэх сэтгэлийг харьцуулж, зарим талаар БНХАУ-ын даргад атаархаж явснаа нуух юун. Тэр ч үүднээс аян замынхаа тэмдэглэлээ Си Зиньпиний нутгаар хэмээн нэрлэсэн хэрэг.

Жуулчдын хөлд дарагдсан Бээжин

БНХАУ-ын Төрийн зөвлөл, Монгол Улсын ГХЯ хамтран зохион байгуулж буй Монголын сэтгүүлчдэд зориулсан ээлжит аялал “БНХАУ-ын инновацийн хөгжилд анхаарлаа хандуулыя” сэдвийн дор болж өнгөрлөө. Бэл бэнчинтэй хөрийнхөө буянаар урьд өмнөх шигээ Замын-Үүд, Эрэнийг дамжилгүйгээр шууд л Бээжин хотод морилох нь тэр. Агаарын хөлдөөр хоёр мянган км замыг хоёрхон цаг туулсан хэрэг. Сүүлийн гурван жил дарааллан алба, амины алив ажлаар Бээжинд морилж буй хэдий ч очих тоололд төөрч будилчих гээд байх болсон нь энэ удаад ялгаагүй. Хөгжил гээч маниус шиг суурин дээрээ ялхайхыг хэлдэггүй бололтой. Хотод миллиард, 300 сая хүн амьдардаг аж. Монгол Улсын хүн ам хэзээ энэ тоонд хүрэхийг хэлж мэдэх юм алга. Ийм олон хүнийг хооллож ундааж, хувцаслахын зэрэгцээ орон байр бэлдэх цаашлаад нэгийг нөгөөгөөс нь ялгахын тулд тийм тооны овог бодож олно гэдэг гайхалтай шүү. Бас нэг нэмж хэлэх зүйл бол ийм их хүн амтай юм чинь Бээжин хот хүнээ багтааж чадахгүй гэвдэж байдаг болов уу гэтэл үгүй юм аа. Суурин суудал 15 сая хүн дээр нь мань мэтийн явуулын улс, дээр нь хэдэн зуун мянгаар дамжин өнгөрөх жуулчид бээжингийнхэнд түвэг удаж байгаа янз алга. Зочид буудал, дэлгүүр хоршоо нь сэлүүхэн талдаа. Бээжин хот 2008 оны олимпоос хойш хоногийн 24 цагтай уралдан хөгжиж байгаа нь



нүднээ илт. Энд тэндгүй өргөгч цамхагууд. Өлийгөөд харах гэхээр нүдний хараа дутахаар өндөр өндөр барилгууд хаа сайгүй сүндэрлэсэн харагдана. Хятад улс өөрийгөө XXI зуунд дэлхийд тэргүүлэх гүрэн болгоно гэж зарласнаас хойш удаагүй байгаа. Тэр дагуу өөрчлөлт шинэчлэлт гэдгийг бүрэн утгаар хийж байгаа нь хэн хүнд анзаарагдам. Түүнийгээ дагаад иргэдийнх нь хандах хандлага соёлжиж, гудамж талбайд нус цэрээ хаяхаа больжээ. Жуулчдад зориулан “Худалдааны гудамж” байгуулан түүний эргэн тойронд тээврийн хэрэгсэл явуулдаггүй нь манай жилдээ нэг удаа зохион байгуулдаг машингүй өдөртэй адилтгаж болохоор.

Түм түжигнэсэн эл гудамжид жуулчид тасралтгүй хөвөрнө. Хаашаа л харна шар толгойтнууд. Бас дотоодын жуулчид ч зөндөө. Тэд харваас андашгүй гартаа “ZARA” тэргүүтэй брэндүүдийн цаасан тор барьсан харагддаг. Харин гадныхан дэлхийн сүлжээ бүхий кофе, тэргэн хоолны газруудыг л эргүүлээстэй. Дэлхийд зартай энэ талбай хэдийнэ жуулчдын хөлд дарагджээ. Жуулчид автобус автобусаар л ирж байгаа харагдсан. Зуны дэлгэр цаг болоод ч тэрүү Африкийн жуулчид бусдаас содон. Тэд Бээжингийн дэлгүүрээс авсан хос шинэ хувцсаараа гангаравч зоогийн газрууд оройн 22:00 цагтай уралдан хаалгаа барьдаг болохоор хаа очихоо мэдэхгүй



дэмий л буудлаа тойрон салхилахаас цаашгүй. Си Зиньпин даргын урилгаар тус улсад хийж буй сэтгүүлчдийн багийн айлчлал Бээжин хотын төв талбай Тянь-Ань-Минь талбайгаас эхэлсэн. Хөтөчний тайлбарласнаар энэхүү талбайд өглөө оройд хэн хүний сонирхлыг татахуйц ёслол болдог аж. Өглөө нар мандмагч агуу Хятадын улаан таван хошуу бүхий тугийг хүндэт харуул занан авчирч мандуулснаар тус улсын төрийн дуулал эгшиглэдэг байна. Үдэш

нар жаргахтай зэрэгцэн үйл явдал давтагдан тугаа авч суурийг нь хүндэт харуулууд манасаар хоцорно. Тоохгүй байхын аргагүй эл үйл явдал бол улс орноо тэр хэрээр сүрлэг, хийморьлог харагдуулдаг юм билээ. Дашрамд өгүүлэхэд, ёслолын ажиллагааг Хятадын нөлөө бүхий компаниуд санхүүжүүлдэг бөгөөд 2028 он хүртэл дараалал дууссан гэж байсан. Нэр төрийн хэрэг л дээ. Эртний Хятадад эзэн хаанаа өргөөнд нь залахын тулд 900 м урт замаар харуул хамгаалт

бүхий орд харшийг нэвтэрдэг байж. Энэ нь цаад утгаараа сүр хүчээ ард түмэндээ харуулах зорилготой байсан биз ээ. Нөгөөтэйгүүр, Хятад улс үеийн үед хүчирхэг удирдагчтай байсан бөгөөд тэднээрээ хойч үе нь ч бахархсаар ирсэн нь Тянь-Ань-Минь тайбайн хойд талд орших музейн хананд залсан Мао даргын хөргөөс анзаарч болно. Дэн Сяо пин, Зян Зэ минь Мао нараа шашнаасаа ч илүү шүтдэг байж мэднэ. Тэр олон сая живаа хүнийг үнэн худал нь мэдэгдэхгүй мудар сүсгээр хуурч байснаас болох хүн шүтэх нь илүү байж болох юм гэж санагдсан шүү.

“Торгоны замаас Нэг бүс- Нэг зам”

БНХАУ-ын дарга Си Зиньпиний урилгаар тус улсад зочилсон Монголын 47 сэтгүүлч Хятадын инновацийн салбарын хөгжилтэй танилцаж, мэдээллийн технологи, и-бизнесийн салбарт дэлхийд тэргүүлэгч группуудын жагсаалтад багтсан Алибаба, Wechat зэрэг олон газраар зочилж, сурвалжиллаа.

Инноваци гэх гадаад үг монголчуудын хувьд шинэ содон зүйл ердөө ч биш. Бидний тухайд өдөр тутмын амьдралаас хол учраас төдийлөн тоохгүй, ойлгохыг хүсэхгүй байж болох юм. Хятад улсын тухайд хэдийнэ биелэлээ олсон төдийгүй эдийн засагт нь өгөөжөө өгөөд эхэлчихжээ. Нэн хурдацтайгаар хөгжиж буй инновацийн салбар “Нэг бүс-Нэг зам” бодлогын салаа мөчир нь аж. Эл үгийг БНХАУ-ын Шинжлэх ухаан технологийн яамны газрын дарга Вү Жнан мин онцолсон. Түүний хийсэн мэдээллээс Монголд хэрэгтэй гэж үзсэн зүйлээ онцлоход, Монгол, Хятад хоёр улс шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллаж, нэн шинэ технологи бүхий хамтарсан лаборатори, парк байгуулах, судалгаа, шинжилгээний үр дүнгээ солилцох талаар хэдийнэ ярилцаад эхэлжээ. Ингэхдээ Монголын шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд, их, дээд сургуулиудтай хамтран ажиллах юм байна. Харин урд хөршийн шинжлэх ухаан, судалгааны байгууллагуудын ололт, нээлтийг Монголын аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлэх талаар сэтгүүлчид Вү даргаас асууж, сонирхоход тэрбээр “Хоёр улс хамтарсан лаборатори байгуулж, мэргэжилтнүүдээ

солилцоно” гэсэн товчхон хариултыг өгнө лээ. Бээжин –Улаанбаатар хоёр агаарын бохирдлоороо адил гэж бичигддэгийн хувьд “Агаарын бохирдлыг бууруулах талаар ямар арга хэмжээ авч байна вэ” хэмээх асуултад “Бид эх үүсвэртэй нь тэмцэж байгаа” гэсэн юм. Эх үүсвэр гэдэг нь хүн амын хэт төвлөрөл, үйлдвэрүүд, автомашин гээд тоочвол юу эс байх вэ. Тиймээс Бээжингийн зүгээс “Соёлтой Бээжин”, “Шинжлэх ухаанч Бээжин”, “Ногоон байгууламжтай Бээжин” болох зорилгыг дэвшүүлжээ. Бээжин хотыг инновацийн салбарын хөгжлөөрөө дэлхийн шилдгийн шилдэг болгох зорилготой байгаагаа Шинжлэх ухаан, технологийн хорооны газрын дарга Гө Рүй бидэнд дуулгасан. Умардынхан эл “мөрөөдөл”-өө биелүүлэхийн тулд 100 мянган мэргэжилтэн бэлтгэж, инновацийн чиглэлээр 13 төсөл хэрэгжүүлж байгаа аж. Харин агаарын бохирдлоос ангирахын тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, Бээжин хотод л гэхэд нэг сая гаруй эко тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулдаг болсон байна. Бээжин хотын удирдлагууд, иргэд, ер бүгдээрээ “Хотын өвчин”-ийг “оношилж”, бүрэн элдгээх арга замаа хэрэгжүүлээд эхэлжээ. БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн яамныхны мэдээлснээр, Хятадад нийт 156 шинэ парк нээснээс 17 нь инновацийн чиглэлийнх гэнэ. Дашрамд өгүүлэхэд, Хятад улс өнгөрсөн онд шинжлэх ухаан, инновацийн салбарт 103 тэрбум ам.доллар зарцуулжээ. Ийм хэмжээний хөрөнгийг улсын төсвөөс гаргасан гэвэл эндүүрэл болно. Төр нь бодлогоор дэмжиж, хувийн компаниуд нь шаардлагатай санхүүжилтийг гаргадаг нь Хятадын инновацийн салбарын хөгжлийн нэг онцлог юм. Тус улс 6000 хүнээ гадаадад энэ чиглэлээр суралцуулж байгаа бол хоёр сая 650 мянган эрдэмтэн зөвхөн инновацийн салбарыг хөгжүүлэхийн төлөө зүтгэж байгаа аж. БНХАУ 2017 оны эхний зургаан сарын байдлаар шинжлэх ухааны 600 паркийг шинэчилж дууссан байна. Түүнчлэн 2025 он гэхэд эдийн засгийн салбар дахь шинжлэх ухаан, инновацийн салбарын үр нөлөөг бүрэн тодорхойлохоор төлөвлөж, үүний тулд “Гурван хот-Нэг бүс” бодлогыг хэрэгжүүлэхээр болсон гэв.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

## Ж.ТЭМҮҮЛЭН: “МОНФРЭШ” КОМПАНИ ДЭЛХИЙН СҮҮНИЙ ӨДРИЙН ХҮРЭЭНД 2000 ЭЭЖИД СҮҮ БЭЛЭГЛЭЛЭЭ

С.ТЭРГЭЛ

*Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөг зургадугаар сарын 9,10-ны өдөр Сүхбаатарын талбайд болж өнгөрлөө. Тэгвэл өнгөрөгч тавадугаар сарын 31-нд тэмдэглэн өнгөрүүлсэн “Дэлхийн сүүний өдөр”-ийн хүрээнд “Монфреш” ХХК-аас нээлттэй хаалганы өдөрлөгт хүрэлцэн ирсэн бүх эзжүүдэд “Монфреш” цэвэр сүүг бэлэглэв. Өдөрлөгийн үеэр тус компаний Ерөнхий менежер Ж.Тэмүүлэн тэй уулзаж ярилцлаа.*

**“Танай компани ХХААХҮЯ-ны нээлттэй хаалганы өдөрлөгт хэд дэх жилдээ оролцож байна вэ?”**

- Анхны жилдээ оролцож байна. ХХААХҮЯ-аас зохион байгуулж байгаа энэхүү өдөрлөгийн хүрээнд ээжүүддээ бид сүү тараалаа. Тодруулбал, тавдугаар сарын 31-нд болдог “Дэлхийн сүүний өдөр”-ийг нээлттэй хаалганы үеэр хамтатган тэмдэглэв. Дэлхийн сүүний өдрийг тохиоцуулан “Монфреш” компани 2000 ээжид монгол үхрийн сүүгээр үйлдвэрлэсэн 0.5 хувийн

тослогтой цэвэр сүү бэлэглэсэн. Бага багаар тараахгүй бол хүмүүс дараалал үүсгэх байх гэж бодсон учраас хүрэлцэн ирсэн ээжүүддээ бэлэглэсэн. Хоёр өдөр болж өнгөрөх өдөрлөгөөр нийт 2000 сүү тараахаар төлөвлөж, амжилттай хэрэгжүүллээ. Сүүлийн дөрвөн жил “Монфреш” ХХК шингэн сүү хүлээн авах төвүүдийг ашиглалтад оруулж, энэ чиглэлд хөрөнгө оруулан ажиллаж байна. Нээлттэй хаалганы өдөрлөгт шингэн сүүн бүтээгдэхүүнүүдээр оролцож байгаа.

**“Шинэ үйлдвэр ашиглалтад оруулна гэсэн. Шингэн сүүнээс өөр ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр эхэж байгаа вэ?”**

-Франц технологиор бяслаг үйлдвэрлэж байгаа. Бяслаг маань хараахан худалдаанд гараагүй байна. Жилдээ 100 орчим тн бяслаг үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтад оруулахаар эхэж байгаа. Бүтээгдэхүүнүүддээ шингэн үйлдвэрлэлд шилжүүлэх бүх төслүүд хэрэгжиж байгаа. Өнөөдрийн өдөрлөгт оролцож, 2000 ээжүүддээ сүү бэлэглэж байгаа нь нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж байгаа томоохон ажлуудын нэг юм.

**“Нийгмийн хариуцлагынхаа**

**хүрээнд сүүлийн үед өөр ямар томоохон үйл ажиллагаа зохион байгуулав?”**

-Эх үрсийн баяраар жижиг бүтээгдэхүүнүүдийн сав баглаа боодлоор хэн сайн бүтээл урлах вэ? “Монфрешийн Ергөнц” уралдааныг 11 дэх жилдээ ЕБС-ийн хүүхдүүдийн дунд зохион байгууллаа. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд Сайн үйлсийн аяныг манай компаниас зохион байгуулж ирлээ. Монфреш компани 1998 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж аян, сайн үйлсийн аянаа явуулдаг. Тухайн сард үйл ажиллагаагаа явуулж байгаа нийгэмлэгүүд эсвэл шаардлагатай байгаа гэр бүлүүдтэй дүүрэг дүүргийн нийгмийн ажилтнаар дамжуулан судалгаа авч тухайн гэр бүлийг дэмжих талаар ажиллаж байгаа.



Гэрэл зургийг Л.ГАЛУУЖИН



# ДЭЛХИЙ

## Умард Солонгос тив алгасах баллистик пуужин харвана гэв

Тив алгасах баллистик пуужин харвах өдөр ойртож байна гэж Умард Солонгос мэдэгдсэн байна. Умард Солонгосын Ажилчны намын “Rodong Shinmun” сонин бямба гарагийн дугаартаа энэ тухай мэдээлсэн юм. Стратегийн зэвсгийн Пхеньяны сүүлийн туршилтаас үзэхэд тив алгасах баллистик пуужин харвах өдөр ойртсон болох нь харгагдаж байна. “Хвасонг-12” гэдэг дунд зайн тусгалтай баллистик пуужинг тавдугаар сарын 14-нд туршсан бөгөөд уг пуужингийн тусгал далайн түвшингээс дээш 2000 км өндөрт хүрсэн байна. Умард Солонгосын эрдэмтэд тив алгасах баллистик пуужинг тээвэрлэх хүчирхэг хөдөлгүүр бүтээх асуудлыг шийдэж чадсан гэж тус сонинд мэдээлжээ. Мөн дэлхийн агаар мандалд дахин нэвтэрч ороход шаардлагатай дулаан эсэргүүцэх технологийг бүтээж чадсан гэж мэдээлсэн юм. Умард Солонгосын удирдагч Ким Жон Ун шинэ жилээр хэлсэн үгэндээ тив алгасах баллистик пуужин хөөргөх бэлтгэл ажил сүүлийн шатандаа явж байна гэж хэлжээ. Түүнээс хойш Умард Солонгосын зүгээс өөрийн технологийн дэвшлийг харуулахын тулд 12 удаа баллистик пуужин харвасан байна.



# Тереза Мэй “САХИЛ ХҮРТЭХ ГЭЭД ШАЛ ДОРДОВ”

Б.ДАВАА

Их Британид одоогоос нэг жилийн өмнө 43 жилийн түүхэнд анх удаа Европын холбооноос гарах эсэх талаар бүх нийтийн санал асуулга болж, иргэд нь гарах сонголтыг хийсэн билээ. Үүнтэй холбоотойгоор тус улсын Ерөнхий сайд Дэвид Камерон огторч, төмөр хатагтай гэгддэг Тереза Мэй дараагийн Ерөнхий сайдаар нэрлэгдсэн юм. Тэр ч үүднээс түүний өмнө ЕХ-ны бүрэлдэхүүнээс гарах томоохон хэлэлцээрийг гардан хийх үүрэг хариуцлага ногдож байлаа.

Улмаар энэ оны гуравдугаар сараас БРИКСИТ-ийг албан ёсоор эхлүүлж буйгаа зарласан билээ. Харин дараа нь буюу энэ сарын 8-нд ээлжит бус парламентын сонгууль явуулахаа мэдэгдэж байв. Уг нь тус сонгуулийг 2020 онд хийхээр төлөвлөж байсан. Хугацаанаас өмнө зарлах болсон шалтгаан нь Европын холбооноос гарах хэлэлцээртэй

салшгүй холбоотой бөгөөд Тереза Мэй өөрийн хувилбарыг парламент дахь суудлынхаа тоог нэмэхээр сонгуулийг хугацаанаас нь өмнө зарласан байдаг. Тухайн үед мэдэгдэлдээ “Европын холбооноос гарах Засгийн газрын төлөвлөгөө бол үндэсний ашиг сонирхол. Гэтэл улс төрийн бусад нам энэ төлөвлөгөөг эсэргүүцэж байна. Бид хагаралдаж хуваагдахын оронд нэгдэх хэрэгтэй байна. Парламентын сонгуулийн хугацааг наашлуулах нь улс орны ирээдүйг тогтвортой байлгах, BREXIT-тэй холбоотой эдийн засгийн эрсдэлээс зайлсхийх зорилготой. Би энэхүү шийдвэрийн цаад шалтгааныг тайлбарлахыг хүсч байна. Өнгөрсөн зун Их Британийн ард түмэн Европын холбоог орхих шийдвэр гаргасны дараа манай улсын хувьд хамгийн чухал зүйл нь тодорхой, тогтвортой байдал болон хүчирхэг удирдлага болсон юм. Хэдийгээр манай улсад санхүүгийн болон


эдийн засгийн аюул нүүрлэнэ гэсэн таамаглал байгаа ч хэрэглэгчдийн итгэл өндөр байгаа төдийгүй ажил эрхлэлт түүхэн дээд хэмжээнд байна. Мөн эдийн засгийн өсөлт таамгийг давсан үзүүлэлттэй байгаа. Их Британи Европын холбоог орхих болно. Бидэнд буцаа зам байхгүй” хэмээж байв. Гэвч сахил хүртэх гээд шал дордов гэгчээр үр дүн нь түүний санаанаар гарсангүй. Их Британид энэ сарын 8-нд болсон парламентын сонгуулиар доод танхимын 650 суудлын 318-ыг “Төмөр хатагтай” гэгддэг Тереза Мэйгийн тэргүүлэх эрх баригч Консерватив нам авсан бол хамгийн том сөрөг хүчний нам болох Хөдөлмөрийн нам 262 суудал авчээ. Харин Шотландын ардын нам 35, Либерал ардчилсан нам 12 суудал гэх зэргээр үлдсэн суудлыг жижиг намын нэр дэвшигчид авсан байна. 650 суудалтай Британийн парламентад доод тал нь 326 суудал авсан нь олонх болдог. Тиймээс Тереза Мэйгийн нам

энэ удаа олонхи болж чадахгүй болжээ. Нөгөөтэйгүүр, сонгууль түүний намд бус, сөрөг хүчинд 30 суудал нэмчихлээ. Одоо долоо хоног хүрэхтэй үгүйтэй хугацааны дараа Британи-Европын холбооны хэлэлцээр албан ёсоор эхлэх юм. Тэгвэл сонгуулийн үр дүнтэй холбоотойгоор эвдрээт нөхцөл байдал үүссэн өнөө үед эрх баригч намын дарга бууж өгөхгүй бололтой. Түүний ажлын албанаас өчигдөр мэдэгдэл гаргаж, эрх баригч Консерватив нам олонх болж чадаагүй учир Умард Ирландын Ардчилсан холбоо намтай эвслийн Засгийн газар байгуулахаа зарлалаа. Саяны сонгуульд Ардчилсан холбоо нам парламентад 10 суудал авсан юм. Улмаар тус намтай эвссэнээр суудлынх нь тоо 328 болох билээ. Ямартай ч, Тереза Мэй туснамынхангай энэ сарын 10-нд уулзалт хийж, тодорхой нөхцөлтэйгөөр тохиролцоонд хүрчээ. Түүнчлэн, Ерөнхий сайд Германы канцлер Ангела Меркельтэй утсаар ярьж, “Их

Британи урьдчилан төлөвлөж байсны дагуу ойрын хугацаанд багтаан Европын холбооноос гарах хэлэлцээрээ эхлүүлнэ” хэмээн мэдэгдсэн байна. Гэхдээ ажиглагчдын үзэж буйгаар Консервативчуудын “ялагдал” БРИКСИТ-ын хэлэлцээрт нөлөөлж болзошгүй байгаа юм. Мөн хамгийн сүүлд авсан мэдээллээр эрх баригч намын дээрх алхмыг эсэргүүцэгчид гарын үсэг цуглуулж эхэлсэн бөгөөд одоогоор 600 мянган хүн Ардчилсан холбоо намыг Консервативтай эвсэхийг эсэргүүцэн гарын үсгээ зуржээ. Нөгөөтэйгүүр, Их Британийн сонгуулийн үр дүн гарсны дараа Тереза Мэйг Ерөнхий сайдын албан тушаалаас нь огцруулахыг шаардсан мэдэгдлүүд гарч эхэллээ. Орон нутгийн хэвлэлд нийтлэгдсэнээр түүнийг огцруулахыг дэмжигчид Гадаад хэргийн сайд Борис Жонсонг дараагийн Ерөнхий сайдад дэвшүүлэх санал гаргаад буй гэнэ.

## Москвад дөрвөн хүний амь хөнөөсөн хэрэг гарчээ

ОХУ-ын нийслэл Москва хотын зах орчимд өнгөрөгч бямба гарагт гэрээсээ гал нээж, дөрвөн хүний амь хөнөөсөн хэрэг гарчээ. Улмаар цагдаа нар хэргийн газарт ирж, томоохон хэмжээний буудалцаан болсон байна. Сэжигтний талаарх мэдээлэл одоогоор тодорхойгүй байна. Гэхдээ хэргийг мөрдөн шалгаж буй Холбооны мөрдөх товчооноос мэдээлснээр Москва хотын зүүн өмнөд хэсэгт байрлах Кратово гэх тосгонд 50 гаруй насны эрэгтэй өөрийн гэрээсээ жирийн иргэд рүү гал нээжээ. Үүний улмаас нэг хүн эмнэлэгт хүргэгдсэнээс гадна мөн гурван хүний цогцос олдсон байна. Түүнчлэн, аюулгүйн албаны нэг ажилтан шархадсан аж.



## Британийн онгоц Германд ослын буулт хийжээ

Словениас Их Британийн нийслэл Лондонд чиглэсэн Британийн иргэний агаарын тээврийн “Easy Jet” зорчигч тээврийн онгоцонд зорчиж явсан нэгэн этгээд “Сэжиг бүхий зүйл ярсан” гэх мэдээлэл нислэгийн удирдлагад иржээ. Улмаар онгоц чиглэлээ өөрчлөн Германы Кёльн хотын нисэх буудалд ослын буулт хийсэн байна. Мөн сэжигтэй яриа өрнүүлсэн гэх гурван эрэгтэй зорчигчийг цагдаагийн байгууллага саатуулжээ. Германы цагдаагийн газрын төлөөлөгч “Франц пресс” агентлагт өгсөн ярилцлагадаа “Словенийн нийслэл Люблянаас Лондонд чиглэлд нислэг үйлдэж байсан онгоцонд бүлэг залуус террорист халдлагатай холбоотой зүйл ярьж байна гэсэн

мэдээлэл хэд хэдэг зорчигчоос нисэх багийнханд ирсэн юм билээ. Үүнтэй холбоотойгоор нисгэгч чиглэлээ өөрчилж, ослын буулт хийсэн. Одоогоор тэдний ярианы агуулгын талаар олон нийтэд мэдээлэх боломжгүй” гэж ярьсан байна. Онгоц энэ сарын 10-ны өдрийн оройн 18:00 цагт Кёльнд газарджээ. Цагдаагийнхан тухайн үед онгоцонд зорчиж явсан 151 зорчигчийг буулгасныхаа дараа гурван сэжигтэн эрэгтэйг баривчилсан байна. Одоогоор тэдгээр сэжигтнүүд хэн болох, үнэхээр террорист халдлага үйлдэхээр зэхэж байсан эсэх нь тодорхойгүй байна.

## М.Темер албан тушаалдаа үлдлээ

Бразилийн сонгуулийн шүүхээс Ерөнхийлөгч Мишель Темериийг 2014 оны сонгуулийн үеэр хууль бус санхүүжилт хийсэн хэргээр буруутгаж албан тушаалаас нь огцруулах тухай хэргийг хэрэгсэхгүй болгожээ. М.Темер өмнөх Ерөнхийлөгч Дильма Руссеффтэй хамт ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж өнгөрсөн жил түүнийг ерөнхийлөгчийн суудлаасаа огцроход орлож үлдсэн билээ. Сөрөг хүчний хууль сахиулагчид сонгуулийн компаниат ажилд хууль бус мөнгө ашигласан учир сонгуулийн үр дүнг хүчингүй болгохыг шаардсан



юм. Хэдийгээр М.Темериийн талд шийдвэр гарсан боловч, улс төрийн үймээн самуун үргэлжлэх төлөвтэй байна. Тодруулбал, шүүх прокурорын байгууллагаас түүний авлигын хэргийг шалгаж эхэлжээ. Мөн М.Темериийг албан тушаалаасаа огцрохыг олон нийт шаардсаар байгаа юм.

# НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 220 дугаар тогтоолоор 7 ширхэг авто машиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэв.

### 1. Дуудлагаар худалдах хөрөнгийн танилцуулга:

№	нэрс	Гарал үүсэл	Үйлдвэрлэсэн огноо	Ашигласан хугацаа	Марк	Техникийн үзүүлэлт	Улсын бүртгэлийн дугаар	Төлөв байдал	Худалдах доод үнэ	Дуудлагын худалдаанд тавих дэнчингийн хэмжээ
1	Зил 130	Орос	1989	28	ЗИЛ-130	УРАЛ 10	27-45 УБХ	Бүрэн ажиллагаатай	3000000	750000
2	Ландкрузер -80	Япон	1991	6	TOYOTA	4160 cc	13-45 СЭҮ	Хурдны хайрцаг эвдэрсэн	9000000	2250000
3	Асио автобус	Солонгос	2000	6	KIA	3000cc	66-89 СЭА	Бүрэн ажиллагаатай	900000	225000
4	Фургон	Орос	2009	8	УАЗ	2890cc	23-87 СЭА	Бүрэн ажиллагаатай	7000000	1750000
5	Фургон	Орос	2010	7	УАЗ	2890cc	40-41 СЭА	Бүрэн ажиллагаатай	5100000	1275000
6	2 Голт Чиргүүл	Орос	1975	19		зил-130	55-77 АЧ	Бүрэн ажиллагаатай	50000	12500
7	Мотоцикль	Хятад	2010	7		150cc	04-14 СЭЗ	Засвартай	20000	5000

### Дуудлага худалдааны ерөнхий мэдээлэл

Дуудлагын худалдаа болох хугацаа	2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 0930 цагт
Дуудлагын худалдаа болох газар	Хорих 433-р ангийн хурлын зааланд газар
Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл	Худалдан авагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө.
Дэнчинг байршуулна	тушаана

### Дуудлагын худалдаанд хүсэлт ирүүлэх

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийг 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 09 цаг 00 минут хүртэлх хугацаанд хорих 433-р ангийн Эдийн засагч Ахмад Г.Мөнх-ундрахын өрөөнд хүлээн авна.

### Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлт нь зөв, цэвэр бөглөсөн хугацаандаа худалдаанд оролцох хүсэлтийн маягт, дэнчин төлсний нотлох баримт, иргэний үнэмлэх / хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ/-ний хуулбар зэрэг баримтаас бүрдэнэ.

### Худалдах хөрөнгийн талаар мэдээлэл авах

Дуудлагаар худалдах хөрөнгийг өмч эзэмшигч Хорих 433-р анги дээр очиж үзэж болох бөгөөд дуудлагын хөрөнгийн талаар мэдээллийг 99334325, 99164878 дугаарын утсаар авна уу.

# NO STRESS

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Шөнийн гэрэлт гудамжтай болмоо



Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр 31  
Шөнө 13

Нөгөөдөр  
Өдөр 26  
Шөнө 14

### Өдрийн зурхай

**ХАВРЫН АДАГ ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН МОРЬ ӨДӨР**

Үс засуулбал: Эд малын гарлагатай  
Наран ургах/ шигэх: 05:02-20:48



Аргын тооллын 6 сарын 12, Сумъя гараг. Билгийн тооллын 18, Элдэв тэнгэртэн одтой, цагаан морь өдөр. Өдрийн наран 5 цаг 02 минутад мандан, 20 цаг 48 минутад жаргана. Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ ололоцх, халтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурил хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, тангагаар тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэтцэл хийхэд луу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаравал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиролжгүй.

Нью Йорк, Токио, Сеул, Бээжин, Банкок, Куала-Лампур зэрэг хөгжилтэй хотуудын худалдаа үйлчилгээний шөнийн гудамж, захууд нь жуулчид амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, худалдаа үйлчилгээ авах бүхий л нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдаг. Тэгвэл нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Улаанбаатар хотыг Зүүн хойд Азийн аялал жуулчлал, бизнесийн төв болгох зорилтын хүрээнд Сөүлийн гудамжийг автомашингүй шөнийн гэрэлт гудамж болгон тохижууллаа.

Циркийн уулзвараас “Наран плаза”-гийн уулзвар хүртэлх нийслэлд анхных гэж хэлж болохуйц шөнийн гудамжны нээлт энэ сарын 8-нд болсон юм. Хуучнаар Сөүлийн гудамжны сул шороон хөрс бүхий талбайг хатуу хучилттай болгож явган замыг нэмэгдүүлэн олон нийтэд зориулсан үзвэрийн дэлгэц, 400 хүний амралтын суудал бий болгожээ. Мөн ногоон байгууламжийн нөхөн сэргээлт, сэлгээлт, авто зам болон явган замын гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл зэрэг орчны тохижилтын ажлыг хийсэн байна. Бүтээн байгуулалтын ажил цаашид ч үргэлжлэх юм. Шөнийн гудамж дээгүүрээ гэрлэн таазтай байхаас гадна гудамжны хоёр тал тэр чигтээ гэрлэн чимэглэлтэй байх бөгөөд гэрэлтүүлгийн эффектуудийг шинэчилж, орчин үеийн дизайныг бий болгожээ.

Гэрэл зургийг Г.АГУУЖИН



### Бидэнд тохиолдсон

ХҮНДХЭН ХӨГТЭИ ЯВДЛУУД

Unurzaya Altansukh

Манай хүү гурван настай. Талхан дээр түрхдэг бүхий л зүйлсийг масло гэдэг гэж боддог нөхөр байгаа юм. Тэгээд дээр хадам ээж малын шар тос өгсөн түүнийг хөдөөний масло гээд варенийг улаан масло гэдэг. Өчигдөр дэлгүүрт хамт орсон чинь “Ээж ээж миний баас шиг өнгөтэй масло аваарай” гэдэг байгаа. Юу яриад байгаа юм гэсэн чинь гүйж очоод элэгний нухаш аваад ирэх жишээтэй. Цаашид ямар төрлийн масло идэхийг би таашгүй нь ээ. Аа тийм өчигдрөөс нэмж асуусан хүмүүсийн харнуулт шоколадны кремийг хар масло гэж байна лээ хаха.

## УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗҮҮ" ЭМНЭЛЭГ



Манай эмнэлэг дотор 5 цуа, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлалт анагаах ухааны таван заслын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

- Бид танад:**
- Ган болон мөнгөн зүү, шахнагаан зүү
  - Хануур, сам соруул
  - Шарлага
  - Бумба төөнө засал
  - Халуун чулуу, давсан халуун жин засал
  - Эмчилгээний цэгэн барил
  - Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн барил зэрэг уламжлалт анагаах ухааны эмчилгээ үйлчилгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ  
Холбогдох утас: 9999-5584  
9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг Улаанбаатар их дэлгүүрийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III хороолол, 28 дугаар сургуулийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Хэвтүүлэн эмчилнэ/